

Гарчиг

ОРШИЛ	8
Тайлангийн Зорилго	8
Товч танилцуулга.....	8
Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны харьяалал.....	8
ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	9
Түүхэн товчоон	9
Газар нутгийн онцлог	9
Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд.....	9
Физик газарзүй, байгаль цаг уурын нөхцөл	9
Цаг агаарын төлөв байдал, олон жилийн төлөв	10
ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
Гадаргын болон газрын доорхи ус	10
Хөрс.....	11
Ургамалжилт	11
Биологийн төрөл зүйл.....	11
ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	14
Байгаль орчны бодлого.....	14
1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	15
Ажиллах горим, ажлын цаг	16
Ажлын байр	16
Нийгмийн хариуцлага.....	17
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
2.1 Агаарын чанар.....	25
2.1.1 Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааг оновчтой зохион байгуулах, технологийн замууд болон овоолго зэргийг усалж чийглэх, хуурайшилттай үед усалгааг ойртуулах, усалгааг явуулахдаа уурхайгаас шавхан зайлуулах ус ашиглан тоосыг бууруулж ажиллана. Тоосжилт дарах бодис туршиж үзэх.	25
2.1.2 Ил уурхайн карьерт тээвэрлэлт хийх машины хурдыг хязгаарлаж 30 км/цагаас хэтрүүлэхгүй байх, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах ажилд хяналт тавих	27

2.1.3 Нүүрс тээврийн ачилтын хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр анхаарч, шаардлага тавьж ажиллах.	27
2.1.4 ШТС-ын талбайд асгарч, дуссан шатахуун, тос, тосолгооны материалыг цэвэрлэх элс бэлдэх.	28
2.1.5 Шатахуун хадгалах савны битүүмжлэлд хяналт тавих	28
2.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөц.....	30
2.2.1 Жил бүр үйлдвэрийн болон ахуйн усны хэрэглээний тооцоо хийж, ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай хийх.	36
2.2.2 Уурхайгаас ус шавхан зайлуулалд хийхэд ашиглаж буй насосын тоолуурын хэвийн ажиллагаанд байнга хяналт тавих.	37
2.3. Хөрсөн бүрхэвч	38
2.3.1 ШТМ-ыг асгарч байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах.....	38
2.3.2 Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх, байгаль орчныг хамгаалах самбар байрлуулах.	38
2.3.3 Хөрсний овоолго болон ил уурхайн тэлэлт хийхэд тухайн хэсгийн шимт хөрсийг стандартын дагуу хуулж авах	39
2.3.4 Шатах тослох материал хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж мэдээллийн самбар, санамж байрлуулах	39
2.3.5 ШТС-ын дамжуулах шугам хоолойн холболтын эд ангиуд болон нээх, хаах битүүмжлэлийг шалгах, хяналт тавих.....	40
2.3.6 Шатахуун буулгах, түгээх үед санамсаргүй асгарсан шатахууныг хөрсөнд шингэхээс өмнө даруй цэвэрлэх.....	40
2.3.7 Шатахуун хадгалах савны насжилт уртасгах бүрхүүл тогтоох будалтын ажилд хяналт тавих	40
2.4. Газрын хэвлий	41
2.4.1 Байгууламжуудтай холбоотой бий болсон газрын эвдрэлийг багасгах, засах, уурхайн үйл ажиллагаанд өртсөн талбайд тухай бүрд нөхөн сэргээлт хийсэн.....	41
2.5. Ургамлан нөмрөг.....	41
2.5.1 Олон салаа зам нь ургамлан нөмрөг, хөрс эвдэх аюултай тул авто техникийн хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулж хяналт тавина.	41
2.5.2 Тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилогч олон наст ургамлыг тарих бодлого баримтлаж ажиллана.....	42
2.6 Амьтны аймаг	43
2.6.1 Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж, байнгын хараа хяналт тавих.....	43
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	44
3.1 Техникийн нөхөн сэргээлт	47

3.1.1 Овоолгын талбай тэлэх үед үржил шимт хөрсийг хуулан авч нөхөн сэргээлтэд хэрэглэхээр хадгална. Хуулсан шимт хөрсийг овоолго хийж стандартын дагуу бүтцийг нь алдагдуулахгүй хадгалах арга хэмжээ авна.....	47
3.2 Биологийн нөхөн сэргээлт:	47
3.2.1 Ажилчдын хотхон орчмын талбайд хөрсийг нөхөн сэргээж зүлэгжүүлж, цэцгийн мандал, мод, бут тарина.	47
3.2.2 Уурхайн талбайд тарьсан мод бут уулын ахилт, тэлэлтэд өртөж болзошгүй мод бутыг шилжүүлэн суулгах.....	49
3.2.3 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт 10га газар 15000ш заг мод тарьж ургуулах.....	50
3.2.4 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ажилчдын хотхоны мод үржүүлгийн талбайд тарьсан мод бут шилжүүлэн тарих, үрээр нэмж тарих.....	52
3.2.5 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ажилчдын хотхоны мод үржүүлгийн талбайд ургасан болон Гурвантэс сумаас модны үр түүж бэлтгэх.....	53
3.2.6 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд гарсан бодлого шийдвэрийг дэмжин ажиллах бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилогч мод, бутны үрийг түүж бэлдэх, тарих, туршилт судалгаа явуулж тарьц суулгацын нөөц бүрдүүлнэ.	53
3.3 Татан буулгах, хаалтад бэлтгэх	54
3.3.1 Хуулсан шимт хөрсийг хадгалах, төслийн үйл ажиллагаа дууссаны дараа хөрсийг бүтцийн дагуу дахин хучиж сэргээнэ. Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хадгалах	54
4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....	55
4.1 Тухайн сонгон авсан талбайд амьтдын амьдрах орчныг сайжруулах	57
4.1.1 Уурхайн ойр орчмын ургамал, хар сүүлт түүний амьдрах орчин бусад зүйлийн амьтдын тоо толгойн мониторинг судалгаа хийж бүртгэж байх.....	57
4.1.2 Талын пост хэмээх газар зэрлэг ан амьтдын зориулсан инженерийн хийц бүхий уст цэг 2021 онд байгуулагдсан түүний хэвийн ажиллагаа болон зэрлэг ан амьтан ундаалж байгаа зэрэгт хяналт тавих	60
4.1.3 Төсөл хэрэгжих хугацаанд гам, зуд ихтэй жилүүдэд зэрлэг ан амьтдын идэш тэжээлийг бэлдэх биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	60
4.2 Байгаль орчныг хамгаалах	61
4.2.1 Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан сургуулийн хүүхдүүд болон иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.....	61
4.2.2 Орон нутгийн иргэд болон орон нутгийн захиргаанаас санал болгосон тус бүс нутагт хамгаалах шаардлагатай байгаа булгийн эхийг сэргээж хөв байгуулах.....	62
4.2.3 Тооройн судалгаанд үндэслэн баянбүрдийг хамгаалах, ундаргыг нэмэгдүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх	62
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	63

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	63
“Тэмээн сүргийн баяр 2025”	64
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	70
7.1. Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	70
7.1.1 Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан уурхайлалтыг хүрээлэн буй орчин болон хүн малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатайгаар зохицуулан ажиллах	70
7.1.2 Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахуудыг гадаргын урсцаас хамгаалах ба тэдгээрээс бохирдол зөөгдөхөөс хамгаалсан далан шуудуу засаж сэргээх.....	70
7.1.3 Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах.....	70
7.1.4 Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах.....	71
7.2 Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	72
7.2.1 Үйлдвэрлэлд гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж мөрдөх.....	72
7.2.2 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	73
7.2.3 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх ..	74
7.2.4 Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэрэгслээр хангах	75
7.2.5 Ажилд гарахын өмнө эмчийн үзлэгт бүх ажиллагсдыг хамруулах.....	75
7.2.6 Гал унтраах багаж хэрэгслээр иж бүрэн хангах, шаардлагатай газарт байрлуулах, зориулалтын дагуу ашиглах, холбогдох хүмүүс тэдгээрийг ашиглах арга ажиллагаанд суралцсан байх	76
7.3 Шатах тослох материалын сөрөг нөлөөлөл.....	77
7.3.1. Галын багаж, хэрэгсэл авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгаж, сэлбэж байх.....	77
7.3.2 Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах.....	77
7.3.3 Шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт явуулах	77
7.3.4. ШТС-ын аюулгүй байдал, бүрэн бүтэн байлгах үүднээс харуул хамгаалалтын ажилтан байнгын байрлах.....	78
7.3.5. Шатах тослох материал ачиж буулгах, цэнэглэх хэсгийг хатуу хучилттай болгон, алдагдаж асгарсан тохиолдолд хөрсөнд нэвчүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	78
8. ХОГ, ХАЯДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	80
Хог хаягдал.....	80

Шингэн хаягдал.....	80
8.1 Ахуйн хог хаягдал.....	84
8.1.1 Хог хаягдлыг цуглуулахад стандартын шаардлага хангасан савыг сонгох, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газруудад байрлуулах, засварлаж байх	84
8.1.2 Хог хаягдлын ангилан ялгалт тухай бүр хийнэ.....	84
8.1.3 Хог хаягдлыг түр хадгалах цэгүүдийн зэрэглээс хамааран хашлага хийх бүрэн бүтэн байдалд хяналт тавих.....	85
8.1.4 Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших	85
8.1.5 Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах ажилд бусад уурхайнуудтай хамтран ажиллах	86
8.2 Үйлдвэрийн хог хаягдал.....	86
8.2.1 Машин механизмаас эд анги, ашиглагдсан тос, тослох материал, шатахуун, аккумулятор, дугуй гэх мэт сэлбэг хэрэгсэл, дахин ашиглагдах хоёрдогч түүхий эдийг тодорхой түр цэгт төвлөрүүлэн хуримтлуулан хадгалж байгаад хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлнэ.	86
8.3 Аюултай хог хаягдал	87
8.3.1 Аюултай хог хаягдлыг зориулалтын саванд түр хадгалах /шатах тослох материал/ ..	87
8.3.2 Аюултай хог хаягдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагуудтай гэрээлэн нийлүүлэх замаар эх үүсвэр дээрээс зайлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх.....	87
9.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	88
9.1 Агаарын чанар.....	91
9.2 Гадаргын болон газрын доорх ус	91
9.3 Хөрсөн бүрхэвч	92
9.4 Амьтны аймаг.....	92
11.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	94

Зургийн жагсаалт

Зураг 1 Хүрэн толгой уурхайн байршил.....	8
Зураг 2 Уурхайн ерөнхий зураг	15
Зураг 3 “Хүрэн толгой Коал Маининг” ХХК ажилчид	16
Зураг 4 Замын усалгаа хийх буй байдал	25
Зураг 5 Тоос дарах бодис туршиж буй явц.....	26
Зураг 6 Замын усалгаа арчилгаа хийж буй байдал	27
Зураг 7 Тэмдэг тэмдэглээ байршуулсан байдал.....	27
Зураг 8 Хяналт тавьж буй байдал.....	28
Зураг 9 ШТС элс бэлэн байдал	28
Зураг 10 ШТС битүүмжлэх сав сольсон байдал.....	29

Зураг 11 Худаг№46150.....	30	
Зураг 12 Худаг№46150-02.....	30	
Зураг 13 Худаг№46150-03.....	30	
Зураг 14 Ашиглаж буй усны тоолуурууд	30	
Зураг 15 Ундны ус цэвэршүүлэгч.....	31	
Зураг 16 Ахуйн ус цэвэршүүлэгч	Зураг 17 Цэвэр ус	31
Зураг 18 Цэвэрлэх байгууламжийн план зураг	33	
Зураг 19 Уурхайн шүүрлийн ус	36	
Зураг 20 Ус ашиглах дүгнэлт	36	
Зураг 21 Акт үйлдсэн байдал	37	
Зураг 22 Талбайн эмх цэгцийг хангаж буй байдал	38	
Зураг 23 Батлагдсан зам талбай.....	38	
Зураг 24 Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, хэлбэржүүлэлт	39	
Зураг 25 Мэдээллийн самбар байршуулсан байдал.....	39	
Зураг 26 Хяналт тавьж буй байдал.....	40	
Зураг 27 ШТС цэвэрлэгээ.....	40	
Зураг 28 ШТС будалт хийж буй байдал.....	41	
Зураг 29 ШТС талбай шилжүүлж буй байдал.....	41	
Зураг 30 Зөвшөрөгдсөн зам талбай	41	
Зураг 31 Царгас ургалт болон хураалт.....	42	
Зураг 32 Царгас тарьж буй байдал	43	
Зураг 33 Талбайн хяналт	43	
Зураг 34 ХТКМ шимт хөрсний овоолго	47	
Зураг 35 Оффис гаднах орчин.....	48	
Зураг 36 Цэцэгт ургамал тарилт	48	
Зураг 37 Хаврын мод тариалалт	49	
Зураг 38 Мод шилжүүлэн суулгах явц.....	49	
Зураг 39 Заг мод тарих талбай.....	50	
Зураг 40 Заг мод тарих ажлын үйл явц	51	
Зураг 41 Нарны цахилгаан үүсгүүр.....	52	
Зураг 42 Заг мод тарьсан 10 га талбай	52	
Зураг 43 Хонингийн булаг	53	
Зураг 44 Модны үр.....	53	
Зураг 45 Хүлэмжинд тарилт хийсэн байдал	54	
Зураг 46 Шимт хөрсний овоолго	54	
Зураг 47 Судалгаа хийсэн байршил	57	
Зураг 48 Судалгааны үед тааралдсан амьтад	60	
Зураг 49 Хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж буй байдал	60	
Зураг 50 Биотехникийн арга хэмжээ	61	
Зураг 51 Дэлхийн усны өдөр зохион байгуулсан.....	62	
Зураг 52 Талбайн байршил.....	62	
Зураг 53 Тоорой мод хашсан байдал.....	63	
Зураг 54 Тэмээчдийн баяр 2025 хөтөлбөр	64	
Зураг 55 Тэмээчдийн баяр 2025	65	
Зураг 56 “Тэмээн сүргийн баяр 2025” үзэсгэлэн худалдаа	66	

Зураг 57 “Тэмээн сүргийн баяр 2025” тэмээний магтаал.....	66
Зураг 58 Галын сургалт зохион байгуулж буй байдал	71
Зураг 59 Галын аюулгүй байдлын үзлэг	71
Зураг 60 Техникийн үзлэгийн хуудас	72
Зураг 61 Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт хийсэн байдал	73
Зураг 62 Сургалтын явц.....	75
Зураг 63 Сар бүрийн захиалга.....	75
Зураг 64 Анхан шатны үзлэг хийж буй байдал.....	76
Зураг 65 Галын хор бэлэн байдал.....	76
Зураг 66 Бэлэн байдал.....	77
Зураг 67 ГУШТ, АҮХШТ, ГХТөлөвлөгөө	77
Зураг 68 Сургалт орж буй байдал.....	78
Зураг 69 ШТС харуулын пост.....	78
Зураг 70 Хатуу хучилттай талбай.....	79
Зураг 71 Хогийн сав байрлуулалт	84
Зураг 72 Хог хаягдлын сургалт орж буй байдал.....	84
Зураг 73 Ахуйн хог хаягдал ангилан ялгалт.....	85
Зураг 74 Хог хаягдлын цэг	85
Зураг 75 Их цэвэрлэгээ хийж буй байдал	86
Зураг 76 Хог хаягдал тээвэрлэж буй байдал.....	86
Зураг 77 Хаягдал тос ачуулж буй байдал	87
Зураг 78 Хэмжилт хийж буй байдал	91
Зураг 79 Усны түвшин хэмжилт.....	92
Зураг 80 Усны дээж авалт	92
Зураг 81 Хөрсний дээж авалт.....	92

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Уурхайд ашиглагдах техник, тоног төхөөрөмж.....	15
Хүснэгт 2 Тоолуурын баталгаажуулалт.....	30
Хүснэгт 3 Судалгааны үед тааралдсан амьтны байршил, тоо толгой.....	57
Хүснэгт 4 Гадаад орчны үзүүлэлтүүд	58
Хүснэгт 5 Судалгааны ажилд шаардлагатай тоног төхөөрөмжүүд.....	59
Хүснэгт 6 ХЭМАБ журмын жагсаалт	73
Хүснэгт 7 Аюулгүй ажиллагааны зааврын жагсаалт.....	73

ОРШИЛ

Тайлангийн Зорилго

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт “Нарийн сухайт”-ын нүүрсний орд газарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа болон Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэлийг хүлээн авсан ажлын хэсгийн дүгнэлт, Өмнөговь аймгийн “Байгаль орчин аялал жуулчлалын газар”-аас гаргасан албан даалгавар зэргийг Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөртөө уялдуулан байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Товч танилцуулга


Манай компани нь анх Монгол улсын хуулийн этгээд “МОНГОЛЫН АЛТ” ХХК, БНХАУ-ын ӨМӨЗО-ны “ЧИН ХУА” группийн 50:50 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2002 оны 09-р сарын 04-нд анх үүсгэн байгуулагдсан.

2003 оны 04-р сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 23 дахь жилдээ ажиллаж байна. Нарийн сухайтын орд газарт “Гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан компани”-ийн статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаад 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн а/02-19 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор БНХАУ-ын хуулийн этгээд “Чин Хуа” корпорацийн эзэмшлийн 50% хувьцааг МОНГОЛЫН АЛТ КОРПОРАЦИ-д, шилжүүлэн авч, 100% үндэсний компани болж, компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт орсон.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт орж, үндэсний компани болсонтой холбоотойгоор компанийн оноосон нэр болох “Чинхуа-МАК Нарийн сухайт” ХХК-ийг “Хүрэн толгой коал майнинг” ХХК болгон өөрчилж, 2020 оны 08 дугаар сарын 04-ний өдөр Хуулийн этгээдийн Улсын бүртгэлд албан ёсоор бүргүүлсэн.

Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны харьяалал

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Урт багийн нутагт Улаанбаатар хотоос ургаш 849 км, Даланзадгад хотоос баруун тийш 296 км, Гурвантэс сумаас зүүн ургаш 34 км, Шивээхүрэн боомтоос 56 км зайд Хүрэн толгой хэмээх газарт явагдаж байна.



Зураг 1 Хүрэн толгой уурхайн байршил

ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Түүхэн товчоон

Гурвантэс сум нь 1954 онд анх Тост нэртэйгээр одоогийн Сэврэй сумын 1 дүгээр баг, Ноён сумын 3, 4, 5 дугаар багууд нийлж Улаан толгой гэдэг газар 281 өрх, 943 хүн амтай, 63,2 мянган малтай байгуулагджээ. 1959 онд орон даяар нэгдэлжих хөдөлгөөн ялсны үрээр, 1960 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Гурвантэс сум гэж нэрлэгдэн, одоогийн байрлаж байгаа Уртын дэнжид төвлөрсөн байна.

Газар нутгийн онцлог

Тус сум нь 2.9 сая га газар нутагтай хойд, баруун, баруун урд талаараа Баянхонгор аймгийн Шинэ жинст, Баянговь, Баянлиг, зүүн, зүүн хойд талаараа өөрийн аймгийн Сэврэй, Ноён, урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эзний хошуутай хиллэж, Говь-Алтайн нурууны цаад цөлөрхөг бүсэд оршдог. Улаанбаатараас 870 км, аймгийнхаа төвөөс 320 км алслагдсан байгалийн үзэсгэлэнт газар ихтэй, цаашид аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой газар нутагтай.

Сумын газар нутгийн ихэнх хэсэг нь олон сая жилийн өмнө амьдарч байсан аварга үлэг гүрвэлийн орон гэгдэх бөгөөд ховор нандин олдвороороо гадаад дотоодын эрдэмтдийн анхаарлыг татаж Зөвлөлт, Польш, Монголын палеонтологичид хайгуул шинжилгээ хийж тэдний ажил шинэ шинэ олдвороор баяжсаар ирсэн юм.Энэхүү олдворууд нь Москва, Варшав, Улаанбаатар, Даланзадгадын музейд өнө эртний аварга динозавр болон сүндэрлэж чимэг болж байна.

Мөн сайн чанарын чулуун нүүрс, давсаар баялаг, алт, төмрийн хүдэр, барилгын сайн чанарын шохой, шохойн чулуу, төрөл бүрийн өнгийн шороон будаг болон гартаам, мана зэрэг үнэт чулуу элбэг тохиолдоно.

Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд

Гурвантэс сум нь засаг захиргааны анхан шатны нэгж болох 5 багтай, эдийн засгийн гол суурь баазаа мал аж ахуйг болгон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх эхлэлийг тавин ажиллаж байна. Тус сум нь 2018 оны байдлаар 4934 хүн амтай 187458 толгой малтай 1558 өрхтэй. Сумын төвд төсөвт 7 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна холбооны салбар, банк, цаг уур, ШТС-ийн зэрэг хувийн хэвшлийн байгууллагууд ажиллаж байна. Сумаас 55 км-т орших Дундголын давсны уурхай, нөхөрлөл нь жилдээ 220 орчим тн давс олборлож борлуулдаг ба сумаас 25 км-т орших нүүрсний орд газарт уул уурхайн компаниуд нүүрс олборлон БНХАУ-д экспортолж байна.

Гурвантэс сум нь цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, цагдаагийн тасаг ажиллаж байна. 2005-2006 оны хичээлийн жилээс 9 жилийн дунд сургууль 12 жилийн сургалттай сургууль болон өргөжсөн. Мөн тус сумын нутагт хилийн цэргийн 0166 дугаар анги байрладгаас гадна “Шивээ хүрэн”-ийн хилийн боомт үйл ажиллагаа явуулж байна.

Холбоо харилцааны хувьд 2006 оны 11 сард мобикомын үүрэн телефон суурилагдан, хүн амын 70 орчим хувь нь гар утас хэрэглэж байна. БНХАУ-ын ӨМӨЗОрны хөрш аймгаас өндөр хүчдэлд холбогдсон, 24 цагийн гэрэл цахилгаантай.

Физик газарзүй, байгаль цаг уурын нөхцөл

Хүрэн толгойн нүүрсний ордын геологийн тогтоц Нарийн сухайтын нүүрсний орд нь Овоот хурлын грабень синклиналийн хойт жигүүрийг үүсгэж байгаа дээд палеозой-доод мезозойн терриген тунамал хурдасны дунд илэрсэн байдгийг өмнөх судлаачид тогтоосон ч сүүлийн үеийн судлаачдын ажлуудаар түүний насыг бүр мезозойны дунд үед хамааруулах хандлага ажиглагдаж байна.

Манай нэртэй эрдэмтдийн Ноён сумын хотгорт ялгасан триасын хурдасны доод талд түүнийг эмжсэн байдлаар нүүрс агуулсан хурдас илэрсэн байдгийг дээд пермийн Дэлийншанд формацид хамааруулсан байдаг юм. Иймээс бид энэ үндэслэлээр Нарийн сухайтын нүүрс агуулсан хурдасыг жиших аргад тулгуурлан дээд пермийн Дэлийншанд формацид, түүнийг хучиж байгаа хурдасыг триасын үеийн Ноён сумын формацид тус тус хамааруулж үзлээ.

Физик газарзүйн мужлалын хувьд Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн мужид хамаарна. Хойд талаараа Бумбын нуруу (2360 м), Тостын нуруу (2517 м), Тахилтын хяр (2316 м) гэсэн 30 км өргөнтэй 180 км үргэлжлэх уулсаар хүрээлэгдэн оршдог. Дээрх уулсаас эх авсан хуурай сайрууд байх ба зарим хэсэгтээ нэлээд өргөн бөгөөд хэдэн арван км үргэлжилдэг бөгөөд урагш хил давтал уруу, хил давтал үргэлжилнэ.

Ордын дүүргийн хувьд харьцангуй өндөр 1525-1560 м. Төв Азийн гадагшаа урсгалгүй ай савд хамаарагдана. Тухайн жилийн цаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим ихээхэн хувьсамтгай бөгөөд их цас орж хайлах, үргэлжилсэн бороотой үед хэдэн арван км үргэлжлэх хуурай сайрууд түр зуурын ширүүн урсгалтай гол болж хувирах ба бороо зогсмогц урсац байхгүй болдог онцлогтой. Хагарлын гарал үүсэлтэй олон тооны булаг тохиолдох ба ихэнх нь мөн урагш урсгалтай бөгөөд элсэн доогуур шурган алга болдог. Хүн малын унданд гар хийцийн худаг хэрэглэдэг бөгөөд усны түвшин нь 1-2 м, заримдаа 5-7 метр байдаг байна.

Цаг агаарын төлөв байдал, олон жилийн төлөв

Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөргийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг явдал юм. Монголд богино (VI сараас VIII сарын дунд хүртэл үргэлжлэх), хуурай зун, ихээхэн хүйтэн, урт (XI сараас IV сар хүртэл үргэлжлэх) өвөлтэй, хавар намрын улирлын үргэлжлэх хугацаа жилээс жилд өргөн хүрээнд хэлбэлздэг онцлогтой. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл $-15-20^{\circ}\text{C}$ хүйтэн, зун $+30+35^{\circ}\text{C}$ заримдаа $+40^{\circ}\text{C}$ хүрч халдаг. Нэгдүгээр сарын агаарын дундаж температур $-14 -18^{\circ}\text{C}$,). Үнэмлэхүй их халуун нь $+28 +44.0^{\circ}\text{C}$ хүрнэ. Говь цөлийн бүсэнд 150-50 мм орчим хур тунадас унах ба хур тунадасны 85% орчим нь жилийн дулаан улиралд /IV-IX сард/ үүнээс зөвхөн 7,8 дугаар сард 50-60% нь орно.

Монгол оронд үлшил бага, цэлмэг өдрийн тоо их, жилдээ 230-260 хоног байх тул жилдээ 2600-3300 цаг нар гийгүүлнэ. Монголын тал хээр, говь цөлийн бүс салхи ихтэй. Жилийн дундаж салхины хурд энэ бүс нутагт 4-6 м/с. Монгол орны нутгийн 41.3%-ийг эзлэх говь цөлийн бүсэд сул шороо элбэг, салхи ихтэй тул шороон шуурга олонтоо тохиолдоно. Энэ бүс нутагт жилдээ 30-100 өдөр, Монгол элсний өмнөд захад жилдээ 120 өдөр шороо хийснэ.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Гадаргын болон газрын доорхи ус

Тухайн бүс нутаг хойд хэсгээрээ Тост (2517м), Хүрэн хана (2397м), Ноёны нам өндөртэй нурууд өргөргийн дагуу зурваслан тогтох бөгөөд уулсын бэлийн дагуу гадаргын харьцангуй өндөр 1600 м хүрнэ. Гадаргын өндөржилт нь урд зүгт аажим налуу үүсгэн, Нарийн сухайтын нүүрсний ордын орчим 1500 м үнэмлэхүй өндөртэй болох ба бага зэргийн талархаг гадаргуу үүсгэн бага зузаантай бэл, хормой хурдсаар хучигдаж олон тооны хуурай сайруудаар хэрчигдэн Нарийн сухайтын тохролоос урагшаа жижиг дов, толгодорхог гадаргатай нийлнэ. Ихэнх сайрууд тухайн уурхайн урд хэсгийн толгодорхог гадаргын ар бэлд тулж садарга үүсгэн сарних ба зарим томоохон сайрууд гадаргын үндсэн хэв шинжид хөндлөн чиглэлд хэрчигдэл үүсгэдэг онцлогтой. Дээр дурдсан гадаргын онцлог шинжүүдээс хамааран бүс нутгийн хэмжээнд газрын доорх усны урсац

пролювийн сэвсгэр хурдсаар дамжин Овоотын бүсийн толгодорхог гадаргад тулахаас гадна өргөргийн дагуу орших Нарийн сухайтын тохрол, дээд пермийн Дэлийн шанд формацын нүүрс агуулагч хурдасны гарш хэсгүүдтэй давхцан газрын гадаргууд булаг хэлбэрээр илэрдэг.

Хөрс

Хөрс – газарзүйн мужлалаар Төв Азийн Говийн их мужийн өргөргийн бүсчлэлийн цөлийн бор саарал хөрс бүхий 10-р тойрогт багтана. Ордын талбайд цөлийн бор саарал хөрс зонхилох боловч булаг шанд бүхий хотгор газраар цөлөрхөг хээрийн нугат бор хөрс алаг цоог байдлаар тархсан.

Ургамалжилт

Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Нарийн сухайтын нүүрсний орд газар нь Алтайн өвөр говийн цөлийн тойрог, Алаша говийн тойрог болон Говь-Алтайн уулын цөлөрхөг хээрийн гэсэн 3 н тойрог хамаардаг учир ургамлын аймгийн хувьд дээрх тойргуудын ургамлын аймгуудын бүрдлийг агуулсан өвөрмөц онцлогтой бүс юм.

Биологийн төрөл зүйл

Ургамлын аймаг, ургамалжилт

Ургамлан бүрхэвчийн тухайд цөл, цөлөрхөг хээрийн сөөг, сөөгөнцөр, заримдаг сөөг зэрэг цөлийн бүсэд дасан зохицсон монгол орны унаган ургамлууд зонхилон тархсан. Ургамалжилтын зонхилох хэв шинж нь зүүн гарын улаан бударганат, хуурай сайрт шар хотир-монгол бүйлст-алтан харгана- улаан бударганат хэв шинжтэй байх бөгөөд өргөн хотгор, уст цэг, булгийн хужир, мараалаг, давстай чийгсэн газарт Сибирь хармаг, Гялгар дэрс, Гоолиг бадаргана, Ширэг улалж, ургасан байдаг.

Бэрээмэг



Тайжийн жинс



Хотир



Улаан бударгана



Шар хотир




Хунчир



Амьтны аймаг

Амьтны аймгийн бүрэлдэхүүний үндсэн хэсгийг говь цөлийн бүсийн амьтад бүрдүүлэх боловч тодорхой хэсгийг нь алтайн уулархаг газрын амьтад болох Аргал, Янгир, зэрэг ховор амьтад уулархаг газраар тохиолдоно. Уурхайн орчимд саарал чоно, үнэг, хярс, туулай, зэрэг хөхтөн амьтад, мөн могой, хонин гүрвэл, олон тооны шувууд байна.



ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны бодлого

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьж ажилладаг.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгон ажилладаг. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах, нөхөн сэргээлтийг стандартын шаардлагад нийцүүлэн боломжит хамгийн их хэмжээгээр хийхэд онцгойлон анхаардаг.


Манай компани байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэж, энэхүү биелэлтийн тайланг бичих.

Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудтай байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, ил тод харилцаж, мэдээлэл солилцох орчныг бүрдүүлэхийг эрхэмлэн ажилладаг.

1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай компани нь 2008-2010 онд ашиглалтын үеийн хайгуул хийж 300 м хүртэлх гүнд 28.6 сая тн нүүрсний нөөцийг нэмэгдүүлэн тогтоож 2011 оны 5 дугаар сарын 27 өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар оруулан Эрдэс Баялаг Эрчим Хүчний Сайдын 2011 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 207 тоот тушаалаар батлуулсан.



Зураг 2 Уурхайн ерөнхий зураг

2025 онд уурхайн үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, нийт **3.0 сая** тонн нүүрс олборлох зорилттой ажиллаж байна. 2025 оны 10 дугаар сарын 25-ний байдлаар нийт **2.0 сая** тонн нүүрс олборлон, үүнээс **2.0 сая тонн** нүүрсийг экспортод гаргаад байна.

Мөн хөрс хуулалтын чиглэлээр **17.0 сая м³** хөрс хуулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа бөгөөд 2025 оны 10 дугаар сарын 25-ний байдлаар нийт **14.1 сая м³** хөрс хуулалтын ажил гүйцэтгэсэн байна.

“Хүрэн толгой” уурхай нь уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд АНУ, Беларусь, Герман, Япон, Хятад зэрэг улсуудад үйлдвэрлэгдсэн 10 төрлийн, нийт 44 ширхэг техник, тоног төхөөрөмжийг ашиглан ажиллаж байна.

2025 онд уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй жагсаалтыг (Хүснэгт 1)-д үзүүлэв.

Хүснэгт 1 Уурхайд ашиглагдах техник, тоног төхөөрөмж

№	Зориулалт	Техник тоног төхөөрөмж	Хүчин чадал	2025 онд ашигласан техник
1	Нүүрс олборлолт	CAT 395-01	6,5m ³	1
2		ZAXIS 870	4.5m ³	2
3	Хөрс хуулалт	EX 1900	18m ³	1
4		CAT 6060	34m ³	1
5		PC2000	12m ³	1
6		RH170B	22m ³	1
7	Өрөмдлөг	Sandvik 75	251mm	2
8	Дугуйт ачигч	CAT 988	13m ³	1
9		LW1200	8m ³	1
10		856H	3.2m ³	2
11	Хөрс тээвэр	CAT 793	240тн	4
12		CAT 777	98.2тн	3
13		HD785	91тн	4
14		Тrex	90тн	6

15		Белаз 75306	220тн	8
16		Белаз 75131	130тн	2
17	Туслах техник	WD900	26м3	1
18		GD825	13м3	1
19		HD785 цистерн	80тн	1
20		CAT D10T	21м3	1
Нийт				44

Ажиллах горим, ажлын цаг

- Ээлжийн үргэлжлэх хугацаа - 11 цаг
- Хоногийн ээлжийн тоо - 2
- Жилд ажиллах хоног - 365

Ажлын байр

Тус компанид нийт 188 хүн ажиллаж байна.

- Орон нутгийн - 18 хүн
- Бусад аймгийн харъяат - 170 хүн



Зураг 3 “Хүрэн толгой Коал Маининг” ХХК ажилчид

Нийгмийн хариуцлага

Орон нутгийн иргэдийн амьжиргаа, жижиг дунд бизнесийг дэмжих үйл ажиллагаа:

- Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих зорилгоор хөдөлмөр хамгааллын бээлийг орон нутгийн компаниас авдаг
- Мөн ажиллах ажилчдын тодорхой хувийг орон нутгаас авах бодлого баримтлан ажиллаж байна.

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажил нь уул-техникийн, инженерийн зураг төсөл, хөдөө аж ахуйн болон бусад төрлийн арга хэмжээнүүдээс бүрдэх бөгөөд эдгээр ажлуудын үр дүнд уулын ажлын явцад эвдэрсэн газрын биологийн үр өгөөж сэргээгдэхээс гадна байгаль орчны төлөв байдал сайжрах ёстой. Уурхайн эвдэрсэн газарт уул-техникийн нөхөн сэргээлт хийж, техникийн нөхөн сэргээлтээр овоолго болон ухшуудыг хэлбэршүүлэн тэгшилж биологийн нөхөн сэргээлтийн ажлыг бүс нутгийн хөрс, ус, агаар мандал, цаг агаар болон уур амьсгал зэргээс хамааруулан ургамалжуулах ажлыг зөв зохистойгоор шат дараалалтайгаар зохион байгуулах шаардлагатай. Биологийн нөхөн сэргээлтийн ажилд шаардлагатай ургамал нь халуун хүйтний улиралд тэсвэртэй тухайн бүс нутагт ургадаг ургамлын төрлийг тарих, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг салхины нөлөөнөөс хамгаалах зорилгоор модлог ургамал тарих ёстой. Хүрээлэн буй орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах улмаар хүмүүсийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах асуудалтай холбогдон уурхайн олборлолтын үйл ажиллагааны дүнд үүсэх өөрчлөгдөж эвдэрсэн газрыг нөхөн сэргээх технологийг боловсруулан эрчимтэйгээр үйлдвэрлэлд нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Стандарт, нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- MNS 5850:2008, Эвдэрсэн газарт хучилт хийх хөрсний стандарт, техникийн шаардлага.
- MNS 5916:2008, “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
- MNS 5917:2008, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага.
- MNS 5918:2008, Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага.

Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, өрөмдлөг, тэсэлгээ, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болж байгаа юм. Мөн хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэх шинж чанартай байна.

Тоосны эх үүсвэрт дараах зүйлс орно:

- Үржил шимт хөрс хуулахад үүсэх тоос,
- Үржил шимт хөрсийг ачих, буулгахад үүсэх тоос,
- Зам барилгын ажлын үед үүсэх тоос,
- Хөрс чулуулгийг хуулахад үүсэх тоос,
- Уулын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоос,
- Бусад үйл ажиллагааны явцад эвдэгдсэн газраас үүсэх тоос.

Тоос нь нүдэнд үл үзэгдэхээс үзэгдэх, усанд үл нордоогоос нордог хүртэлх хэмжээтэй хөрс, шорооны нийлмэл шинж чанартай байна. Төслийн талбай болон түүний ойр орчимд тархах

магадлалтай. Тоосжилт өндөртэй ажлын байранд байгаа хүмүүс, ойролцоо нутаглах иргэд, ургамлын бүрхэвч хамгийн ихээр өртөх магадлалтай.

Хөрсний эвдрэл, элэгдэл

Төслийн үйл ажиллагааны явцад барилга байгууламжийн суурь бэлдэх, зам барих, суваг шуудуу ухах, шугам хоолой татах, хаягдлын далан байгуулах, ил уурхайн бэлтгэл ажилд үлэмж их хэмжээний газар эвдрэлд орж байгалийн унаган төрхөө алдана. Хөрс хуулалт болон төслийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэлд орохын зэрэгцээ үржил шимээ алдах сөрөг нөлөөлөл байна. Уурхайн эдэлбэр газар болон түүнээс гаднах дэд бүтцийн зарим талбай өртөх магадлалтай. Тухайн газрын хөрс, ургамал, амьтан өртөнө. Ил уурхайн бүтээн байгуулалтын ажил эхэлснээр үржил шимт хөрс хуулалт хийгдэж, газрын хэвлийд хонхор үүсэн гүнээс гарах их хэмжээний хаягдал чулуулгийн овоолго газрын хэвлий дээр бий болон газрын ландшафтад өөрчлөлт бий болно.

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Ажилчдын унд ахуйн усны хэрэгцээг цэвэршүүлсэн усаар хангаж байна. Мөн цэвэршүүлсэн бохир усыг дахин ашиглаж болох эсэхийг төрийн байгууллагуудтай хамтран туршилт, судалгааны ажлыг судлах юм.

Ургамал ба амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Хөрс хуулалтаас үүдэн тухайн талбайн ургамлан нөмрөг устаж үгүй болно. Мөн тус газарт нутагшсан амьтад амьдрах орчноо алдана. Уурхайн үйл ажиллагаа ялангуяа хөрс хуулалтаас шалтгаалан янз бүрийн талбайн ургамлын бүрхэвч өртөнө. Ургамлан нөмрөг устсанаас тухайн орчны агаарт өөрчлөлт орж, хуурайшилт бий болно. Уурхайн эдэлбэр газар, дэд бүтцийн зарим талбайн ургамал, амьтан өртөх магадлалтай.

Хог хаягдлын нөлөөлөл

Төслийн барилгын ажлын явцад ажилчдын нийтийн байр, хоолны газар, ажлын байр, засвар үйлчилгээний хэсэг, агуулах зэрэг бүх ажлын байрнуудаас хатуу шингэн хог хаягдал гарна.

- Хатуу хог хаягдал: Ахуйн хог хаягдал, хаягдал мод, төмөр, хуучин дугуй, сэлбэг
- Шингэн хаягдал: Ахуйн бохир ус, ашигласан тос, түлш шатахууны хаягдал

Хатуу шингэн хог хаягдал нь орчны хөрсийг, гүний усыг бохирдуулах боломжтой. Тухайн газрын хөрс, ургамал, амьтан нөлөөлөлд хамгийн түрүүнд өртөх магадлалтай.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүсэх байгаль орчны зөрчил

Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад төрөл бүрийн осол гарч болзошгүй байдаг. Энэ нь үйлдвэрийн барилга болон инженерийн бусад байгууламжийг барьж байгуулах газрыг сонгох, зураг төсөл хийх, тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах, тоног төхөөрөмжүүдтэй харьцаж ажиллах зэрэг бүхий л үйл ажиллагаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер, техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчих, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны хяналт суларснаас элдэв осол гарч, байгаль орчныг бохирдуулах, цаашлаад хүмүүсийн эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг аюул дагуулах эрсдэлтэй тул асуудлыг онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад болзошгүй осол нь дараах хэлбэрээр гарч болзошгүй. Шатах тослох материал, химийн хорт бодистой харьцаж ажиллах арга ажиллагааг мэдэхгүйгээс хөрс, гадаргын болон гүний ус, агаар цаашлаад ургамлан бүрхэвч, амьтанд ноцтой хохирол учруулж болзошгүй. Хордлогод өртөх зэрэг болзошгүй осол гамшиг тохиолдох магадлалтай.

Машин техниктэй холбоотой ажил эрхэлдэг ажилчин албан хаагчид машин техникийнхээ бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавихгүй, засвар үйлчилгээнд хамруулахгүй байснаар шатах

тослох материалын асаралт гарч хөрс, гүний ус бохирдох, зөвшөөрөгдөөгүй замаар тээврийн үйл ажиллагаанд оролцсоноор ургамлан бүрхэвч талхлагдаж, хөрс эвдэрч, тоосжилт үүсэн агаарын чанарт нөлөөлж болзошгүй.

Байгаль орчны сургалтын хөтөлбөр

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой хөгжлийг дэмжих зэрэг үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй байлгах. Дээрх ажлын хүрээнд байгаль орчны сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж нийт ажиллагсдын экологийн мэдлэгийг дээшлүүлэх, байгаль хамгаалах үйлсэд ажилчдыг татан оролцуулах, компанийн байгаль орчны бодлого, хууль эрхзүйн дүрэм журмуудыг танилцуулах зорилгоор нийт ажилчдыг хамарсан байгаль орчны сургалт, мэдлэг олгох ажлуудыг зохион байгуулдаг.

Байгаль орчны сургалтын хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг 2020 онд тавьж ажилласан. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлон тусгай сургалтын материалд тусгаж өгөх,
- Төслийн ажилтан бүр өөрийн хийж гүйцэтгэх ажлаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг мэддэг байх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх ур чадварт суралцахад дэмжлэг үзүүлэх,
- Байгаль орчны зөрчлийг цаг алдалгүй хэрхэн мэдээлэх, зөрчлийг дахин давтан гаргахгүй байхад ажилчдын оролцоог нэмэгдүүлэх,
- Байгаль орчныг хамгаалах талаар ОУ-ын байгууллагуудаас зарлаж буй Дэлхийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх,
- Байгаль орчны ажлын гүйцэтгэл, түүний биелэлтийн тайлан болон бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, нээлттэй өдөрлөгүүдийг зохион байгуулах, зохион байгуулахад оролцох, мэдээллийн хуудас бэлтгэх

Болзошгүй аюул ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

Байгалийн гамшигаас үүсэх болон болзошгүй осол

Байгалийн гамшигт газар хөдлөл, усны үер, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймэр, үйлдвэрлэлийн осол, халдварт өвчин тархах зэрэг үзэгдлүүд хамаардаг.

Газар хөдлөлт

Газар хөдлөлт нь байгалийн гамшгийн хамгийн аюултай хэлбэрийн нэг бөгөөд газар хөдлөлийг урьдчилан тогтоож, мэдээлэх боломж муу. Газар хөдлөлийн үзэгдэл манай улсад харьцангуй цөөн тохиолддог боловч хаягдлын сан бусад барилга байгууламжийг шинээр барьж байгуулахдаа газар хөдлөлийн нөлөөллийг сайтар тооцох шаардлагатай. Газар хөдлөлийн улмаас шугам сүлжээ гажих, тасрах, барилга байгууламжид ан цав гарах, нурах, ус дамжуулах шугам хоолойнууд болон хаягдал дамжуулах хоолой эвдрэх, цоорох гэх мэт хохирол, сүйрэл гарч болзошгүй. Иймээс үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, газар доорх шугам сүлжээг барьж байгуулах болон суурилуулахдаа газар хөдлөлийн хэдэн балл хүртэл тэсвэрлэх чадвартай болон уг үйлдвэрлэлд тохирох эсэх талаар холбогдох мэргэжлийн байгууллагын үнэлгээ, дүгнэлт гаргуулан осол аваарын үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан.

Салхи, шуурга

Говийн бүс нутаг нь хавар, намрын улиралд, ялангуяа хаврын улиралд үе үе хүчтэй салхитай байдаг бөгөөд салхины хамгийн дээд хурд нь 20 м/сек-с хэтрэх тохиолдол тус бүс нутагт олонтоо тохиолддог. Иймээс хаврын улиралд үйлдвэрийн түүхий эд болон бүтээгдэхүүнийг тээвэрлэх, шатах тослох материал, агуулахыг байршуулах, үйлдвэрлэл явуулахад дээрх нөлөөллийг сайтар харгалзан үзэх шаардлагатай. Хаягдлын байгууламжаас салхи, шороон шуурганы давтамж ихтэй хавар, намрын улиралд нарийн ширхэгтэй тоосонцор үүсэж, агаарыг бохирдуулах магадлал өндөртэй. Мөн тухайн нутаг дэвсгэрт цаг агаарын олон жилийн дунджаар 15 м/сек-с их салхитай өдөр 10, шороон шуургатай өдөр 33, цасан шуургатай өдөр 10 удаа тохиолдож, салхины их хурд 16-34 м/сек, ялангуяа хаврын саруудад 28-34 м/сек хурдтай салхилах тохиолдол олон гардаг байна. Тиймээс тоосжилтоос сэргийлэх арга хэмжээг нарийн төлөвлөх шаардлагатай байдаг. Шороон шуурганы үргэлжлэх хугацаа жилд дунджаар 20 өдөр байгаа нь хаягдлын байгууламжийн үйл ажиллагааг хаах үед нарийн ширхэгтэй тоосонцор салхиар тээвэрлэгдэн тархах эрсдэлтэй байна. Ийм учраас хадархаг хөрсөөр хучилт хийх, мөн техникийн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зохих шаардлагын дагуу хийх нь зүйтэй юм.

Үер

Үйлдвэрийн бүс нь олон жилд цөөн удаа тохиолдох үерийн аюулд бага өртөнө. Ус их цуглавал далангийн хаалт сэтгэрч, ихээхэн хэмжээний ус алдагдан орчныг бохирдуулахаас гадна түүнийг сэргээн босгоход шаардагдах цаг хугацаа, хүч хөдөлмөр, эд хөрөнгийн ихээхэн хохирол үүсэж болзошгүйг анхаарах шаардлагатай. Зуны хур борооны үед цаг агаарын нөхцөлөөс хамааран үерийн аюул үүсэж болзошгүй тул далан хаалт сэтгэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх, үйлдвэрийн цогцолборын болон хаягдлын сангийн эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах нь зүйтэй. Үер усны аюул нь зарим тохиолдолд газар хөдлөлийн сүйтгэлээс багагүй хохирол учруулж, хүний амь нас эрсдэх магадлалтайгаас гадна байгаль орчныг бохирдуулах, үйлдвэрийн орчин ус, хөрс, ургамлан нөмрөгт ихээхэн хохирол учруулах нөхцөлтийг мартаж болохгүй юм.

Аянга цахилгаан

Зуны улиралд, ялангуяа хур бороо элбэгтэй 7-8 дугаар саруудад аянга цахилгааны үзэгдлүүд илүүтэй тохиолдоно. Иймд үйлдвэрийн өндөр хүчдэлийн шугам бусад шаардлагатай газруудад аянга зайлуулагчийг байрлуулах шаардлагатай. Тус бүс нутагт зуны улиралд 20 орчим өдөр аянга цахилгаан буудаг байна. 1 кв.км талбайд 4-6 удаа аянгын ниргэлт болдог нь үйлдвэрийн болон уурхайн техник хэрэгсэл, хүмүүсийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн нөхцөлд түр саатал бэрхшээл учруулж, улмаар аюул осол тохиолдож болох магадлалтай. Иймээс шаардлагатай газарт аянга зайлуулагчийг байрлуулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад ажиллагсад металл хийц бүхий тоног төхөөрөмж, байгууламжаас аянга цахилгааны осолд өртөхөөс сэргийлэх шаардлагатай.

Халдарт өвчин тархах

Хатуу, шингэн хог хаягдлыг тогтоосон хугацаанд зайлуулахгүй, удаан хугацаагаар хуримтлуулан хадгалах, ил задгай байлгах, бохир усны цооног халих, хог хаягдлын цэг, жорлон, бохир усны цооногт тогтоосон хугацаанд ариутгал хийхгүй байх, хоол хүнсний хаягдлыг таггүй саванд ил хадгалах зэргээс орчны ус хөрс, агаар бохирдож, халдварт өвчний нян өсч үржих, халдварт өвчин үүсэн тархах нөхцөлтэй. Мөн хоол хүнсийг зориулалтын дагуу зөв хадгалаагүйгээс хүнсний зүйл муудах, ундны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс ус бохирдох зэргээс гэдэс дотрын элдэв халдварт өвчин үүсч, тархах аюултай. Үйлдвэрийн хэмжээнд онцгой байдал, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний тусгай төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай. Осол аваар гарах тохиолдолд яаралтай мэдээлэл дамжуулахын тулд холбогдох хүмүүсийн овог, нэр, хаяг, утсыг тусгайлан бичиж, тохиромжтой газар байрлуулах, энэ талаар ажилчдад тодорхой мэдээлэл өгсөн байвал зохино. Осол аваар гарсан үед түүний хугацаа,

байршил, төрөл хэлбэр, хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл, хамрах цар хүрээг тогтоосны үндсэн дээр шаардагдах хүн хүч, хөрөнгө зардлыг тодорхойлж, ослын үр дагаварыг яаралтай арилгах болон цэвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Ослын хор уршгийг арилгасны дараа түүнийг бүрэн арилсан эсэхэд судалгаа хийж, хяналт тавих шаардлагатай.

Галын аюул

Гал түймэр гарах нөхцөл нь цахилгааны холболтыг буруу хийх, ачааллыг хэтрүүлэх, шалбарч гэмтсэн цахилгааны утас хэрэглэх болон ажиллагсдын хайнга байдлаас үүдэн гал алдах зэрэг болдог. Иймд цахилгаан тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны холболт хийх ажлыг мэргэжлийн байгууллагаар найдвартай хийлгэхийн зэрэгцээ ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж дадлагажуулах хэрэгтэй. Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах, гал түймрээс сэргийлэх багаж хэрэгслийг гарын дор бэлэн байлгах нь зүйтэй.

БО-ны төлөвлөгөө болон БОНБНУ-д тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбогдсон арга хэмжээнүүд

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам, хийсэн ажил

Төслийн дотоод болон гадаад замыг тоос харьцангуй бага босгодог материалаар хучих, замыг хатуу хучилттай болгох, хуурайшилт ихтэй үед зам услах, олон салаа зам гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаа, уурхайн замаар зорчих хурдны хязгаарыг тогтоох зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх нөлөөллийг бууруулах

Газар ашиглалтын хяналтыг сайжруулж, шаардлагагүй ашиглалтыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Ашигласан тос маслыг 30 тн багтаамжтай ёмкостинд цуглуулан дахин боловсруулдаг аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгдөг. Зогсоолын талбайг Tonli, Terex хүнд машин механизмын гэж төрөлжүүлэн тухай бүрд нь бохирдсон хөрсийг цэвэрлүүлж байна. Мөн түүнчлэн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тогтоосон цэгт зохих журмын дагуу зайлуулдаг. Шимт хөрсийг газар хөндөх үйл ажиллагааны өмнө стандартын дагуу хуулан овоолго үүсгэн хадгалах, нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглаж байна. Хур тунадсыг цуглуулах суваг хоолой байгуулан хөрсний элэгдлийг багасгах боломж нөхцөлийг бүрдүүлдэг.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8	9
1.	Агаарын чанар: Уулын ажлын үеийн газар шорооны ажил, техникийг зөөх зэрэг үйл ажиллагааны явцад үүсэх хөрсний эвдрэлээс босох тоосжилт нь орчны тоосжилтыг нэмэгдүүлэх	1.Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааг оновчтой зохион байгуулах, технологийн замууд болон овоолго зэргийг усалж чийглэх, хуурайшилттай үед усалгааг ойртуулах, усалгааг явуулахдаа уурхайгаас шавхан зайлуулах ус ашиглан тоосыг бууруулж ажиллана. Тоосжилт дарах бодис туршиж үзэх	Уурхайн зам-40.47га Овоолго-139.3га	га	1.0	4	4.0	Жилийн турш	Агаарын тухай хууль 18-р зүйл, MNS5885:2008 MNS4585:2007
		2.Ил уурхайн карьерт тээвэрлэлт хийх машины хурдыг хязгаарлаж 30 км/цагаас хэтрүүлэхгүй байх, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах ажилд хяналт тавих.	Төсөлд ашиглагдаж буй замууд	-	ҮЗ	-	-	Жилийн турш	
		3.Нүүрс тээврийн ачааны хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр анхаарч, шаардлага тавьж ажиллах.	Төслийн хүрээнд	-	ҮЗ	-	-	Жилийн турш	
		4.ШТС-ын талбайд асгарч, дуссан шатахуун, тос, тосолгооны материалыг цэвэрлэх элс бэлдэх.	Төслийн хүрээнд, ШТС	-	ҮЗ	-	-	Жилийн турш	ШТС техникийн ерөнхий шаардлага
		5.Шатахуун хадгалах савны битүүмжлэлд хяналт тавих.	Төслийн хүрээнд, ШТС	-	ҮЗ	-	-	Жилийн турш	


2.	Гадаргын ба газрын доорх усны нөөц: Гадаргын болон газрын доорх усны нөөцөд нөлөөлөл үзүүлж болзошгүй	1.Жил бүр үйлдвэрийн болон ахуйн усны хэрэглээний тооцоо хийж, ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай хийх.	Төслийн хүрээнд	Гэрээ, дүгнэлт	0.7	2	1.4	1-р улиралд	
		2.Уурхайн ус шавхан зайлуулалд хийхэд ашиглаж буй насосын хэвийн ажиллагаанд байнга хяналт тавих.	Төслийн хүрээнд	Жилд	0.1	12	1.2	Жилийн турш	
3.	Хөрсөн бүрхэвч: Төслийн талбай болон түүний эргэн тойрны тээврийн хэрэгсэл хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн, доройтох	1.ШТМ-ыг асгарч байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах.	Төслийн хүрээнд, засварын талбай	-	ҮЗ	-	-	Жилийн турш	Хөрс хамгаалах тухай хууль, газрын тухай хууль
		2.Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх, байгаль орчныг хамгаалах самбар байрлуулах.	Төслийн хүрээнд	-	1.0	1	1.0	Жилийн турш	
		3.Хөрсний овоолго болон ил уурхайн тэлэлт хийхэд тухайн хэсгийн шимт хөрсийг стандартын дагуу хуулж авах.	Төслийн хүрээнд	-	ҮЗ	-	-	Жилийн турш	MNS5916:2008
		4.Шатах тослох материал хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж мэдээллийн самбар, санамж байрлуулах	Төслийн хүрээнд	-	1.0	1	1.0	Жилийн турш	ШТС техникийн ерөнхий шаардлага
		5.ШТС-ын дамжуулах шугам хоолойн холболтын эд ангиуд болон нээх, хаах битүүмжлэлийг шалгах, хяналт тавих.	Төслийн хүрээнд, ШТС	-	ҮЗ	-	-	Жилийн турш	
		6.Шатахуун буулгах, түгээх үед санамсаргүй асгарсан шатахууныг хөрсөнд шингэхээс өмнө даруй цэвэрлэх	Төслийн хүрээнд, ШТС	-	ҮЗ	-	-	Жилийн турш	

		7.Шатахуун хадгалах савны насжилт уртасгах бүрхүүл тогтоох будалтын ажилд хяналт тавих.	Төслийн хүрээнд, ШТС	-	ҮЗ	-	-	Жилийн турш	
4.	Газрын хэвлий:	1.Байгууламжуудтай холбоотой бий болсон газрын эвдрэлийг багасгах, засах, уурхайн үйл ажиллагаанд өртсөн зам талбайнуудад тухай бүрд нөхөн сэргээлт хийнэ.	Төслийн хүрээнд,	Тухай бүрт	ҮЗ	Тухай бүрт	-	Жилийн турш	MNS5916:2008
5.	Ургамлан нөмрөг: Төслийн үйл ажиллагаа явагдах орчинд ургамлан бүрхэвч сүйтгэгдэж, доройтно.	1.Олон салаа зам ургамлан нөмрөг, хөрс эвдэх аюултай тул авто техникийн хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулж хяналт тавина.	Уурхайн дотоод замууд	-	ҮЗ	-	-	Жилийн турш	Газрын тухай хууль
		2.Тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилгч ургамлыг тарих бодлого баримтлах.	Төслийн хүрээнд,	Улирал	1.0	2	2.0	Жилийн турш	Ургамал хамгааллын тухай хууль
6.	Амьтны аймаг:	1.Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж, анхааруулах тэмдэг байрлуулж, байнгын хараа хяналт тавих	Төслийн хүрээнд,	-	-	-	-	Жилийн турш	Амьтны тухай хууль
	Нийт						10.6		

2.1 Агаарын чанар


2.1.1 Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааг оновчтой зохион байгуулах, технологийн замууд болон овоолго зэргийг усалж чийглэх, хуурайшилттай үед усалгааг ойртуулах, усалгааг явуулахдаа уурхайгаас шавхан зайлуулах ус ашиглан тоосыг бууруулж ажиллана. Тоосжилт дарах бодис туршиж үзэх.

Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааг оновчтой зохион байгуулан, технологийн замууд болон овоолго бүхий талбайг тогтмол чийглэж ажилласан. Хуурайшилттай нөхцөлд усалгааны давтамжийг ойртуулж, тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайгаас шавхан зайлуулсан усыг ашиглан усалгааг гүйцэтгэсэн. Усалгааны ажилд 2 усны машин тогтмол ажиллаж хэрэглэсэн усны мэдээллийг сар бүр тогтмол бүртгэн ажилласан.



Зураг 4 Замын усалгаа хийх буй байдал

“Хүрэн Толгой Коал Майнинг” ХХК нь уурхайн нүүрс тээврийн зориулалттай 1.15 км урт, 17,000 м² талбай бүхий сайжруулсан шороон замд тоосжилтыг бууруулах туршилт хийсэн. Уг туршилтыг “Эко Сойл” ХХК-тай хамтран хэрэгжүүлж, **DUSTLOC Plus** тоос дарах бодисын нийт **18 тонн**-ыг ашигласан. Энэхүү туршилтын зорилго нь замын тоосжилтыг бууруулах үр нөлөөг үнэлэх, цаашдын хэрэглээнд тохирох технологи, бодисын оновчтой хэрэглээг тодорхойлсон.





Зураг 5 Тоос дарах бодис туршиж буй явц

Зам бүрэн хатсаны дараа Dustloc бодис шүршсэн хэсэг болон энгийн (бодис хэрэглээгүй) замаар тээврийн хэрэгслийг явуулж, нарийн ширхэгт тоосонцор хэмждэг багажаар хэмжин үр дүнг тодорхойлсон. Туршилтаар бодис туршсан хэсэгт нарийн ширхэгт тоосонцор 20-30% буурсан үзүүлэлтэй байна.




График 1 Хэмжилтийн үр дүн

“Хүрэн Толгой” уурхайгаас “Гурвантэс” сум хүртэлх 3.7 км авто замын арчилгааг сар бүр тогтмол гүйцэтгэж байна. Мөн замын дагуу олон салаа зам үүссэн тохиолдолд тухайн замыг хааж, нөхөн сэргээх ажлыг хийдэг бөгөөд гүйцэтгэлийн тайланг сар бүр “Гурвантэс” сумын Байгаль орчны улсын хяналтын байцаагчид хүргүүлдэг.



Зураг 6 Замын усалгаа арчилгаа хийж буй байдал

2.1.2 Ил уурхайн карьерт тээвэрлэлт хийх машины хурдыг хязгаарлаж 30 км/цагаас хэтрүүлэхгүй байх, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах ажилд хяналт тавих

Ил уурхайн карьерт тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тээврийн хэрэгслийн хурдыг **30 км/цаг**-аас хэтрүүлэхгүй байх хязгаар тогтоон мөрдөж байна. Хурдны хязгаарлалттай холбоотой анхааруулах болон мэдээлэх замын тэмдэг, тэмдэглэгээг шаардлагатай газруудад байршуулсан. Энэхүү хэрэгжилтэд ХАБЭА-н хэсэгтэй хамтран долоо хоног бүр хяналт тавьж, зөрчлийг таслан зогсоох, сайжруулах арга хэмжээ авч ажиллаж байна.



Зураг 7 Тэмдэг тэмдэглээ байршуулсан байдал

2.1.3 Нүүрс тээврийн ачилтын хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр анхаарч, шаардлага тавьж ажиллах.

Нүүрс тээврийн ачилтын хэсэгт тоосжилтыг бууруулах зорилгоор бүтээлэгтэй байдлыг хангаж, хяналт тавин ажиллаж байна. Энэхүү ажлыг “Ихэр гурван аргалант” ХХК-тай байгуулсан гэрээний хүрээнд хэрэгжүүлж, нүүрс ачилтын явцад үүсэх тоосжилтыг багасгах, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр тогтмол хяналт, арчилгааг хийж байна.



Зураг 8 Хяналт тавьж буй байдал

2.1.4 ШТС-ын талбайд асгарч, дуссан шатахуун, тос, тосолгооны материалыг цэвэрлэх элс бэлдэх.

Шатахуун түгээх станцын (ШТС) талбайд асгарсан шатахуун, тос, тосолгооны материалыг цаг алдалгүй цэвэрлэх, галын аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай элсийг бэлтгэн бэлэн байдалд хадгалж ажилласан болно.



Зураг 9 ШТС элс бэлэн байдал

2.1.5 Шатахуун хадгалах савны битүүмжлэлд хяналт тавих

Шатахуун хадгалах савны битүүмжлэлд хяналт тавин ажилладаг. МҮТТ ХХК тай ШТС 75 тонны сав шинээр солих гэрээ хийж 2025 оны 1-р сард хийж гүйцэтгэсэн.



Зураг 10 ШТС битүүмжлэх сав сольсон байдал

2.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөц

Уурхайн ажилчдын унд, ахуйн хэрэглээний усны хэрэглээг хянах зорилгоор баталгаажсан усны тоолуур суурилуулсан. Тоолуурыг Байгаль орчны улсын байцаагчаар лацдуулж, орон нутгийн холбогдох байгууллагууд тогтмол хяналт тавин ашиглалтын байдлыг шалгаж байна. Ус хангамж нь гурван худгаас бүрддэг бөгөөд усны хэрэглээг нарийвчлан бүртгэж, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Худгийн код	Байршил	Усны тоолуур	Цооногийн гүн /м/	Ашиглалтын хэлбэр
46150	Ажилчдын хотхон	Байгаа	100	Унд, ахуй ногоон байгууламжийн хэрэгцээ
46150-02	Ажилчдын хотхон	Байгаа	70	Ахуйн хэрэгцээнд
46150-03	Уурхайн тосгон	Байгаа	140	Ахуйн хэрэгцээнд

Хүснэгт 2 Тоолуурын баталгаажуулалт



Зураг 11 Худаг №46150



Зураг 12 Худаг №46150-02



Зураг 13 Худаг №46150-03




Зураг 14 Ашиглаж буй усны тоолуурууд

Ундны ус болон ахуйн хэрэглээг бүрэн хангах зорилгоор ундны ус цэвэршүүлэх хоёр, ахуйн ус цэвэршүүлэх нэг, мөн ахуйн бохир ус цэвэрлэх нэг байгууламж ашиглан үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр байгууламжийн хүчин чадлаар усны хэрэгцээг 100% хангаж байгаа болно. Ахуйн усан хангамжийн системд угаалга, цэвэрлэгээ, угаалтуур, халаалтын систем, ногоон байгууламжийн усалгаанд ашиглагддаг нийт гурван цооног ажиллаж байна.

2025 онд ундны болон ахуйн усны хэрэглээнд тогтмол хяналт тавьж ажилласан бөгөөд 2025 оны 01 дугаар сарын 01-наас 2025 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар унд, ахуй болон ногоон байгууламжийн усалгаанд нийт **5484 м³** ус ашигласан байна.

Ундны ус болон ахуйн ус цэвэршүүлэх байгууламж



Зураг 15 Ундны ус цэвэршүүлэгч



Зураг 16 Ахуйн ус цэвэршүүлэгч



Зураг 17 Цэвэр ус

ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ

Ахуйн бохир усыг цэвэрлэх зориулалттай “**БИОТЕХ 150 Х.Н. С90**” загварын цэвэрлэх байгууламжийг ашиглаж байна. Энэхүү байгууламж нь **ATV-A122** болон **OENORM B-2502-2** нормын шаардлагын дагуу төлөвлөгдсөн бөгөөд биологийн цэвэрлэгээний аргаар хоногт 150 хүний ахуйн бохир ус буюу 22.5 м³ усыг нүүрс усны задралын хувьд 90 хувь хүртэл цэвэршүүлэх хүчин чадалтай юм.

Бохир ус цэвэрлэх байгууламжийн төлөвлөлт, зураг төслийг Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын баталсан MNS EN 12566:2011 “Бага хүчин чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж” стандартыг үндэслэн боловсруулсан. Мөн Герман улсын ATV-A122 “51–500 хүний бохир ус цэвэрлэх байгууламжийг төлөвлөх норм”, Австри улсын OENORM B-2502-2 стандартуудын шаардлагыг давхар мөрдөж, төлөвлөлтийн ажлыг гүйцэтгэсэн болно.

Бохир ус цэвэрлэх байгууламжийн тооцооллыг хийхдээ хоногт нэг хүний усны хэрэглээг 150 литр гэж үзэн үүнд 300 мг/л биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ (БХХ₅) буюу химийн хуурай жингээр 190 грамм бохирдол орохоор тооцсон. Ийнхүү бохирдлыг механик цэвэрлэгээний дараа биологийн аргаар цэвэрлэх явцад хоногт нэг хүнд 60 грамм БХХ₅ зарцуулах нөхцлөөр, бохир усны бохирдлын хэмжээг 40 мг/л хүртэл цэвэршүүлэх үндсэн нөхцлөөр байгууламжийн төлөвлөлтийг хийсэн.

Бохир усны цэвэрлэгээний үр дүнг MNS 4288-2000 стандартын 3.3-т заасан шалгуур үзүүлэлттэй харьцуулан үнэлэхэд шаардлагыг бүрэн хангасан бөгөөд цэвэрлэгээний үр дүн 90% хүртэл байна.

Цэвэршсэн бохир ус нь хоногт 22.5 м³ хэмжээгээр гарч, өвөл, зун аль ч улиралд хоёрдогч тунгаагуураар дамжин шингээлтийн сувагт орж хөрсөнд шингэнэ.

Байгаль орчны нөлөөлөл

Ийнхүү 300 мг/л БХХ₅ агууламжтай бохир усыг 30 мг/л хүртэл цэвэршүүлсний дараа хөрсөнд шингээх нь хөрсний ус болон ойр орших усны худгуудыг бохирдуулахгүй байх үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь Монгол Улсад мөрдөгдөж буй стандарт, нормативын шаардлагад бүрэн нийцэж байна.

Техникийн үзүүлэлтүүд

А. Байгууламж

Цэвэрлэгээний процесс нь бохир усны оролт, цэвэршсэн усны гаралтын байнгын тэнцвэрт урсгалын явц дунд тусгай тоноглолууд / хөвөгч бодис баригч хаалт, хүчилтөрөгчжүүлж хутгагч систем, илүүдэл лаг буцаагч/ бүхий төмөр бетон хийцийн 3 тусгай савнуудад явагдана.

Байгууламжийг анх ашиглахдаа биологи цэвэрлэгээний цооногийг аэроб бактерийн тусгай бэлдмэлээр цэнэглэж, тэдгээрийн зохистой үржих нөхцлийг хүчилтөрөгчжүүлж хутгах системийн тусламжтайгаар хангасан болно.



Зураг 18 Цэвэрлэх байгууламжийн план зураг

Хоногийн цэвэрлэх хүчин чадал	150хүн нэгж /х.н./ буюу 22,5 м ³ бохир ус
Бетон савны нийт эзлэхүүн	90 м ³
<u>1.Механик урьдчилсан цэвэрлэгээ</u>	22,5 м ³
Гүн	2.5м
Гадаргуу(м3/х.н.)	0.1
<u>2. Бактер идэвхжүүлэх сав</u>	45,0 м ³
Хүчилтөрөгч оролт(кг/хоног)	41.5
Хүчилтөрөгчжүүлж хутгагч системийн хүчин чадал	1150 Вт 220 V
Хутгалт	24 м3/цаг
Гаралтын хэсгийн хэсгийн хүчилтөрөгчийн агууламж	2мг/л
Агааржуулалт/амралтын интервал	60 мин/45мин
<u>3. Бактер тунгаах байгууламж</u>	10м3
Лаг буцаах систем	450 Вт
Бетон хийцийн зузаан	25 см
Гаднах бохир дамжуулах хоолойн материал	PVC
Дамжуулах хоолойн диаметр	DN 160,PVC,Герман
Бохир усны урсгалын дундаж ачаалал	2,2 м ³ /цаг
Хүн нэгж ноогдол	150 л бохир ус /хоног
Нэгж бохирдолт	60 гр БХХ ₅ х.н. хоног
Хоногийн цахилгаан зарцуулалт	26,4 кВт/хоног
Бактерийн индекс	75-150 мл/гр
Бохир усны оролт/буцах лагийн харьцаа	1,0
Цэвэршсэн усыг хөрсөнд шүүж шингээх байгууламж	
Нийт талбай	100м ²

Анхдагч нийт эзэлхүүн	250м ³
Шингээлтийн хоолойн урт	100м
Шингээлтийн сувгийн материал	PVC, DN 110
Шингээлтийн сувгийн суултын гүн	2,8м
Хэт яагаан туяаны ариутгагч	4х36вт,200-280нм, 260нм тах

Б. Бохирын оролтын үеийн /үнэмлэхүй/ бохирдолт

Биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ / БХХ ₅ /	9,0кг/хоног
Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ /XXX/	18,0 кг/хоног
pH – утга	6-7
Дээд температур,зундаа	40°С
Доод температур,өвөлдөө	8°С
Нийт химийн хуурай усгүй жинлэгдэх бодис	28,5 кг/хоног
Нийт азот	55 мг/л

В. Цэвэрлэгээний үр дүн

Биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ / БХХ ₅ /	<30 мг/л (>90%)
Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ /XXX/	<60 мг/л
pH – утга нийт азот фосфат	Саармаг 10мг/л /1000 хүнээс доош байгууламжинд хянах шаардлага тавигддаггүй/ Мөн 1000 хүнээс доош бол хянах шаардлага тавигддаггүй

Г. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Цэвэрлэх байгууламжийн суултуур, тосгуур, цэвэрлэгээний шугамд дараах төрлийн материалыг хаяхыг **хатуу хориглоно**:

- Механик хог хаягдал
- Нийлэг материал бүхий салфетка, уут, сав
- Эмэгтэй хүний ариун цэврийн хэрэгсэл
- Архины болон пивоны бөглөө
- Тамхины иш

Эдгээр нь биологийн задралд орохгүй бөгөөд шахуургын дамарт орооцолдох, хоолойг бөглөх зэрэг **аюултай нөхцөл үүсгэдэг**.

Мөн байгууламжид дараах бодисыг хийхийг хориглоно:

- Халдваргүйжүүлэх, ариутгалын бодис
- Хортон шавьж устгалын бодис
- Хүчил, шүлт, антибиотикийн бэлдмэл

- Угаалгын ажиллагаанд хэрэглэгддэг цайруулагч бодис, ялангуяа хлорт нэгдлүүд (жишээлбэл, хлорын хэт исэл) өндөр тунгаар тогтмол хэрэглэх

Эдгээр дүрмийг мөрдөж ажилласнаар **багууламжийн тоноглолын эвдрэлээс сэргийлэх** болон **биологийн цэвэрлэгээний үр ашгийг хадгалах** үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ.

Д. Ашиглалт, арчилгаа, үйлчилгээ

Цэвэрлэх процессыг явуулахдаа бохир усны агааржуулалт, илүүдэл бактер буцаах системүүдийн уялдаатай ажиллагааг зохистой горимоор автоматжуулсан тул байгууламжийн ашиглалтын явцад механик болон биологийн цэвэрлэгээний нийт дамжлагуудад байнгын арчилгаа, үйлчилгээ шаардагдахгүй. Гэсэн хэдий ч дараах арчилгаа, шалгалтыг тогтмол хийх шаардлагатай.

- Өдөр тутам нэг хүн агааржуулалтын систем болон лаг буцаах шахуургын хэвийн ажиллагааг шалгах
- Долоо хоногт нэг удаа хог баригчийг авч цэвэрлэх
- Жилд нэг удаа илүүдэл лагийг лагийн талбай руу стандартын дагуу гадагшлуулах
- Хоёр жил тутам хэт ягаан туяаны төхөөрөмжийн лампыг солих

Эдгээр арга хэмжээ нь байгууламжийн хэвийн ажиллагааг хангаж, биологийн цэвэрлэгээний үр ашгийг тогтмол хадгалахад чухал юм.

Е. Баталгаат хугацаа

Бетон байгууламжийн баталгаа	40 жил
Цахилгаан тоног төхөөрөмжийн баталгаа	24 сар

Уурхайн шүүрлийн ус

Хүрэн толгой уурхайн ашиглалт, ухалтын явцад шүүрсэн усыг уурхайн мөргөцөгт байгуулсан дренаж системээр хамгийн доод талын зүмгэнд хуримтлуулж, нөхөн сэргээлтийн усалгаа болон тоосжилтыг бууруулахад ашигладаг. Жилийн турш уурхайд орж ирэх усны хэмжээ тодорхойгүй, харилцан адилгүй байх боломжтой бөгөөд зарим үед ус огт шүүрэхгүй тохиолдол гарч болно. Энэ нь тухайн жилийн хур тунадас, цаг агаарын нөхцлөөс хамаардаг.

2025 онд ус ашиглах дүгнэлт, гэрээний дагуу уурхайн шүүрлийн ус нийт 55,012м³ гарсан.

Ус ашиглах тооцоо :

- Зам, талбайн усалгаа- 33,007.2 м³
- Мод, ногоон байгууламжийн усалгаанд: 22,004.8 м³

Уурхайн шүүрлийн усыг ус ашиглах дүгнэлт, гэрээний дагуу 2024 оны 12-р сарын 15-наас 2025 оны 10-р сарын 25-ны хооронд **47260.8 м³** хэмжээгээр ашигласан. Мөн төрийн байгууллагын шаардлага, хэрэглээг хянах зорилгоор шүүрлийн ус хуримтлуулсан хэсгээс автоцистерн/усалгааны машин ашиглан шахах насос-ын тусламжтайгаар зам талбайн тоосжилт бууруулах болон ногоон байгууламжийн усалгааг хийж байна.



Зураг 19 Уурхайн шүүрлийн ус

2.2.1 Жил бүр үйлдвэрийн болон ахуйн усны хэрэглээний тооцоо хийж, ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай хийх.

Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-аар 2025 оны 03 сарын 27 өдөр E-2502-000347 дугартай “Ус ашиглах дүгнэлт” гаргуулан хүлээн авсан. Үүний дагуу “Алтайн өвөр говийн сав газар”-тай “Ус ашиглах гэрээ” болон “Хаягдал усны дүгнэлт” гаргуулан ажилласан.



УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 3 дугаар сарын 27-ний өдөр
Дугаар E-2502-000347
Улаанбаатар хот
Утас: 265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Огноосон нэр: Хурэн толгой коал майнинг ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 2697947
Регистрийн дугаар: 2697947
Захирагч: Нантгай
Холбоо барих дугаар: 11353128
Факс:
И-мэйл хаяг:

2. Төслийн нэр, байршил

Төслийн нэр: Хурэн толгой
Байршил: Өмнөговь, Гурвантэс, 4-р баг, Бага-Овоо
Харьяалагдах сав газар: Алтайн өвөр говийн сав газар
Хэвээрх салбар: Уул уурхай
Төслийн дэлгэрэнгүй: Өмнөговь аймаг, Гурвантэс сумын нутагт 70.47 га талбай бүхий МҮ-005459 тусгай зөвшөөрөлтэй хурэн толгойн нуурын ордыг ил аргаар ашиглах төсөл.

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр
Хурэн толгой коал майнинг

4. Ажиллах горим, хүчин чадал

Ургэлзэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хонот ажиллах өмнөхөн	Хонот ажиллах цаг
3	2 эвлээр	365	221	24

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажлын үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжээ нэгж	Тайлбар
Уурхайн уулгад суурин орж ирэн усны хэмжээ	155.38	м3	Усны газрын 2024.05.06-ны өдрийн 54 дугаар усны ашиглах боломжит төсвийн дүгнэлт, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Хурэн толгой ордын 2025 оны үүрэн ажлын төлөвлөгөөнд 155.38 м3-ийн шүүрлийн усыг аргуйлан ашиглахад тусгасан байна. 38 хуудас.



ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2025 оны 05-р сарын 20-ний өдөр
Дугаар E-2504-000431

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

Огноосон нэр: Хурэн толгой коал майнинг
Улсын бүртгэлийн дугаар: 2697947
Регистрийн дугаар: 2697947
Захирагч: Нантгай
Холбоо барих дугаар: 11353128

1.2. Төслийн нэр, байршил:

Төслийн нэр: Хурэн Толгой
Үйлдвэрлэх үйлчилгээний зориулалт:
Байршил: Өмнөговь, Гурвантэс, 4-р баг, Урт
Дэлгэрэнгүй хаяг: Өмнөговь, Гурвантэс, 4-р баг, Урт, Төв байр, 44 тоот
Харьяалагдах сав газар: Алтайн өвөр говийн сав газар

Хоёр. Хаягдал усны талаарх мэдээлэл

2.1. Хаягдал ус хаях цагийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин

Хаягдал ус нийлүүлэх хэлбэр: Байгальд нийлүүлэх
Нийлүүлэх буй хаягдал усны төрөл:
Намдат тайлбар:







2.2. Хаягдал усны хэмжээ










Зураг 20 Ус ашиглах дүгнэлт

2.2.2 Уурхайгаас ус шавхан зайлуулалд хийхэд ашиглаж буй насосын тоолуурын хэвийн ажиллагаанд байнга хяналт тавих.


2025 онд унд ахуйн болон уурхайн шүүрлийн усны хэрэглээнд хяналт тавьж ажилласан бөгөөд сар бүрийн 25-ны өдөр Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Байгаль орчны улсын хяналтын байцаагчидтай усны төлбөр, усны тоолуурын хяналтын актыг үйлдэн, баталгаажуулалт хийж байна.

Хугагийн тоолуурын хяналтын акт 2025 оны 9-р сар

№	Хугагийн нэр, төрөл	Тоолуурын заагт		Сарын хэрэглээ м³	Тоолуурын зураг		
		2025.08.25	2025.09.25		2025.08.25	2025.09.25	Тоолуурын гэрчилгээ
1	Ажиргааны хөгжим Унд ахуйн хуудал /66150-02/ 362 Ногоон байгууламж /7/3 уусуурайн тоолуурын унд ахуйн хэрэглээг хасаж тооног/	69589 м³	70877 м³	1288			
2	Унд ахуй	13954 м³	14387 м³	433			
3	Уурхайн тосгон мөх ардуулагчийн усны тоолуур /66150-03/ 363	11468 м³	11468 м³	0			

4	Уурхайн тосгон Унд ахуйн тоолуур /66150-01/ 364	1826 м³	1833 м³	7			
5	Зөвч тоолуур/ тоолуур 365	6403 м³	6403 м³	0			
6	Зөвч тоолуур/ тоолуур 366	12912 м³	12912 м³	0			

Сарын нийт: 1295 м³ Унд ахуй: 440 м³ Ногоон байгууламж: 855 м³ Шүүрэл: 0 м³

Баталгаажуулалт хийсэн:
Өмнөговь аймгийн Гурвантэс сумын
Орон нутаг харуулан байгаль хамгаалагч:  А.Бүжиг
Байгалийн
"Мандалын Аг" ХХК-ийн
Усны менежментийн нэгж/агийн _____ /Н.Тэнгисдорж/


Зураг 21 Акт үйлдсэн байдал

2.3. Хөрсөн бүрхэвч

2.3.1 ШТМ-ыг асгарч байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах.

Бохирдсон тос, тослох материалыг уурхайн засварын талбайн зүүн урд байрлах тос солих цэгт, 30 тонн багтаамжтай ёмкост хийж, хөрсний бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Хөрсний бохирдол үүссэн үед бохирдсон хөрсийг хусаж цэвэрлэн, бохирдолтой хөрсний талбайд байршуулан бохирдсон хөрсийг саармагжуулан ажиллаж байна.

Мөн “Об ойл индустрал” ХХК болон “Түмэн эгшиг” ХХК-тай хаягдал тос, гидрийн шингэн нийлүүлэх гэрээ байгуулан, нийлүүлэн ажиллаж байна.



Зураг 22 Талбайн эмх цэгцийг хангаж буй байдал

2.3.2 Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх, байгаль орчныг хамгаалах самбар байрлуулах.

Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх зорилгоор ажлыг зөвшөөрөгдсөн, батлагдсан замын маршрутын дагуу зохион байгуулан, замуудыг нөхөн сэргээж, хөрсний сул шороотой зам талбайг усалгаа хийж агаарт дэгдэх тоосжилтыг бууруулан ажиллаж байна.



Зураг 23 Зам талбайн арчилгаа

2.3.3 Хөрсний овоолго болон ил уурхайн тэлэлт хийхэд тухайн хэсгийн шимт хөрсийг стандартын дагуу хуулж авах

Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, хамгаалалт болон хэлбэржүүлэх ажлыг MNS 5916:2008 стандарт болон ордын ТЭЗҮ, БОНБНҮ-ний тайланд тусгасан зааврын дагуу гүйцэтгэсэн. Хөрсний үржил шимийг алдуулахгүйн тулд салхинд хийсэхээс сэргийлж, карьераас ус, мөс авчран байнга усалж, чийгшүүлж байсан. Энэхүү ажлыг Хүрэн Толгойн уурхайн жилийн уулын ажлын төлөвлөгөөнд тусган, төлөвлөгөөний дагуу тогтмол гүйцэтгэж байна. Уурхайн хөрсний овоолгын ахилтад өргөж буй шимт хөрсний овоолгын урд хэсгийг шилжүүлэн хэлбэржүүлсэн. Шимт хөрсний овоолгын дугаарлалтыг самбарыг байршуулсан.



Зураг 24 Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, хэлбэржүүлэлт

2.3.4 Шатах тослох материал хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж мэдээллийн самбар, санамж байрлуулах

Техник тоног төхөөрөмжийн тосолгоо үйлчилгээг засвар үйлчилгээний төвд 50м² хатуу хучилттай зориулалтын талбайд хийж байна. Хөрс бохирдохоос сэргийлэн 2024 онд бетонжуулан самбар байршуулсан. 2025 онд тэмдэг, мэдээллийн самбар нэмж байрлуулан ажилласан.



Зураг 25 Мэдээллийн самбар байршуулсан байдал

2.3.5 ШТС-ын дамжуулах шугам хоолойн холболтын эд ангиуд болон нээх, хаах битүүмжлэлийг шалгах, хяналт тавих

ШТС-ын дамжуулах шугам хоолойн холболтын эд ангиуд болон нээх, хаах битүүмжлэлийг ХАБЭА хэсэгтэй хамтран 7 хоног бүр тогтмол хяналт тавин ажилласан.



Зураг 26 Хяналт тавьж буй байдал

2.3.6 Шатахуун буулгах, түгээх үед санамсаргүй асгарсан шатахууныг хөрсөнд шингэхээс өмнө даруй цэвэрлэх

ШТС станцад шатахуун буулгах, түгээх үеэр хөрсний бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлж ажилтнуудад зааварчилгаа өгч, санамсаргүй асгарсан тохиолдолд тухай бүр элс, шингээгч материал ашиглан яаралтай цэвэрлэж, бохирдсон хольцыг тусгай зориулалтын саванд цуглуулж, бохирдсон хөрсийг түр хадгалах талбайд буулган саармагжуулах арга хэмжээг авч ажиллаж байна.



Зураг 27 ШТС цэвэрлэгээ

2.3.7 Шатахуун хадгалах савны насжилт уртасгах бүрхүүл тогтоох будалтын ажилд хяналт тавих

Шатахуун хадгалах савны ашиглалтын хугацааг уртасгах, зэврэлтээс хамгаалах, шатахууны ууршилт болон байгаль орчинд сөрөг нөлөө үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын бүрхүүл тогтоох, гадаргууг будгаар хамгаалах ажил хийж гүйцэтгэсэн.

Будгийн ажлын гол зорилго нь савны гадаргууг агаар, чийг, температурын хэлбэлзэл болон химийн нөлөөллөөс хамгаалах, ингэснээр зэврэлт, цоорол, шатахуун алдагдах эрсдэлийг бууруулахад чиглэнэ. Мөн хамгаалалтын будаг нь нарны гэрэл, халалтын нөлөөг багасгаж, шатахуун уурших, даралт ихсэх, галын аюул үүсэхээс сэргийлэх чухал ач холбогдолтой. Будаг болон бүрхүүлийн материалыг MNS болон олон улсын ISO стандартын шаардлагад нийцсэн, шатахуун хадгалах зориулалтын тусгай хамгаалалтын будаг сонгон хэргэлсэн.



Зураг 28 ШТС будалт хийж буй байдал

2.4. Газрын хэвлий

2.4.1 Байгууламжуудтай холбоотой бий болсон газрын эвдрэлийг багасгах, засах, уурхайн үйл ажиллагаанд өртсөн талбайд тухай бүрд нөхөн сэргээлт хийсэн.

Шатахуун түгээх станцын үйл ажиллагаатай холбоотойгоор бий болсон газрын эвдрэлийг засаж, илүү ашиглагдаж байсан 55м² талбайд нөхөн сэргээлт хийж янзалсан.



Зураг 29 ШТС талбай шилжүүлж буй байдал

2.5. Ургамлан нөмрөг

2.5.1 Олон салаа зам нь ургамлан нөмрөг, хөрс эвдэх аюултай тул авто техникийн хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулж хяналт тавина.

Зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээврийн үйл ажиллагаа явуулж, шороон замуудыг нөхөн сэргээж, хөрсний сул шороотой зам талбайг усалгаа хийж агаарт дэгдэх тоосжилтыг бууруулан ажиллаж байна.



Зураг 30 Зөвшөөрөгдсөн зам талбай

2.5.2 Тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилогч олон наст ургамлыг тарих бодлого баримтлаж ажиллана.

Манай компани нутгийн унаган ургамал болох сухайг 2005 оноос хойш тарималжуулан ургуулж байгаа бөгөөд нөхөн сэргээлтэд хамгийн тохиромжтой нь сухай, жигд гэсэн дүгнэлтэд хүрээд байна.

Мөн 2018 оноос эхлэн царгас тарьж туршилт хийгээд байна. Царгас нь хөрсний үржил шимийг байнга дээшлүүлж байдаг. Энэ нь байгаль орчинд үзүүлж байгаа нэг чухал сайн нөлөө мөн. Сүүлийн жилүүдэд газар тариалангийн атаршуулж орхисон талбай, мөн уул уурхайн эвдэрсэн талбайд царгас тариалах замаар нөхөн сэргээдэг олон улсын туршлага юм. Царгасыг 0.6 га талбайд тариалаад 2 дахь жилээс эхлэн боловсорч гүйцсэн 2021-2025 онд 4-6 удаагийн ургац авч малчин иргэдэд өгч арга туршлагаасаа хуваалцаж байна. Уурхайн нөхөн сэргээлт болон гадна тохижилтод ашиглах бүрэн боломжтой ургамал гэсэн дүгнэлтэд хүрээд байна.



Зураг 31 Царгас ургалт болон хураалт

Багийн иргэдийн хурлын саналын дагуу тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилогч олон наст ургамлыг тарих ажлын хүрээнд нутгийн малчин О.Энхбатын хашаанд олон наст царгас ургамал 490 м² талбайд тарьсан. Намираа усалгааны хоолой 30м тавьж усалгааны асуудлыг шийдсэн.





Зураг 32 Царгас тарьж буй байдал

Гурвантэс сумын Бага-Овоо багийн төвийн ногоон байгууламжийн мод, бут сөөгний арчилгаа болон усалгааны ажлыг зохион байгуулах хүрээнд, мод услах моторт төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор шаардлагатай бензиний хангамжийг бүрдүүлж ажилласан.

2.6 Амьтны аймаг

2.6.1 Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж, байнгын хараа хяналт тавих.

2025 онд хур бороо элбэг зуншлага сайн байсан тул мал, амьтан уурхайн бүс, мод үржүүлгийн талбайд идэш тэжээл хайн орж ирэх давтамж цөөн байсан. Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж, байнгын хараа хяналт тавин ажиллаж байна.



Зураг 33 Талбайн хяналт

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай компани үйл ажиллагаа эхэлсэн 2003 оноос хойш 23 жилийн хугацаанд уурхайн мод үржүүлгийн талбайд болон ажилчдын хотхоны тохижилт зэрэгт жигд, сухай, бургас, улиас, гацуур, голт бор зэрэг нийт 15000 мод, сөөг тарьж ургуулан арчлан хамгаалж байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт ургаж байгаа модны өндөр нь 6 м, дунджаар 3.5 м орчим байгаа бөгөөд жигдийн 90 орчим хувь нь үр жимсээ өгч байна.

2025 оны хувьд сухай болон жигд бусад модны ургалт хэвийн байсан бөгөөд өмнөх жилийн үзүүлэлттэй ижил титэм салаалалтын хувьд 20-55 см, улаан сухай 10-18 см, бургас 30-60 см ургасан. Эдгээр модноос тайралт хийн мөчрөөр нь үрслүүлэн плантци байгуулах боломж бүрдсэн. Үүнээс гадна дээрх модны үр жимс нь боловсорч гүйцэх, ургах орчин нь олон тооны үр идэшт шувуудын амьдрах таатай нөхцөл болоод байна. Мөн шувуудын амьдрах орчинг улам сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд говийн нөхцөлд дасан зохицсон модлог ургамлыг тарьж ургуулахыг зорилго болон ажилласан бөгөөд тухайн орчинд хамгийн сайн зохицон ургаж нутагшиж байгаа ургамал бол хайлаас, жигд, сухай юм.

Манай компани нутгийн унаган ургамал болох сухайг 2008 оноос хойш тарималжуулан ургуулж байгаа бөгөөд нөхөн сэргээлтэд хамгийн тохиромжтой нь сухай, жигд гэсэн дүгнэлтэд хүрээд байна. Энэ нь тухайн ургамлын биологийн онцлог болоод ургах орчинтой холбоотой юм. Биологийн онцлогийг нь ашиглаж карьерын салхин дээд талд нь тарьж эхэлсэн бөгөөд үр жимс боловсорч гүйцээд салхины нөлөөгөөр ургах таатай нөхцөл бүрдэн бий болсон газарт /карьер/ ургаж байна. Өөрөөр хэлбэл салхин талд нь тарьсан сухайн боловсорч гүйцсэн үр нь карьерын /гулсалтын чийглэг, нөмөрлөг газарт салхины аясаар туугдан унаад бие даан ургаж байгаа юм.

“Хүрэн толгой коал майнинг” ХХК-ийн ашиглалтын талбайн, ойжуулах, нөхөн сэргээх газрын ургамал, төрх байдлын судалгааг МУИС, БИОЛОГИ, БИОТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ-тай хамтран хийсэн. Энэхүү судалгааны дүгнэлтийн дагуу 2025 оны нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулан ажилласан болно.

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт: БОНБНУ-ний дагуу, уурхайн хаалт 2032 онд хийгдэж эхлэх тул техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.	1.Овоолгын талбай тэлэх үед үржил шимт хөрсийг хуулан авч нөхөн сэргээлтэд хэрэглэхээр хадгална. Хуулсан шимт хөрсийг овоолго хийж стандартын дагуу бүтцийг нь алдагдуулахгүй хадгалах арга хэмжээ авна.	га	2	0.7	1.4	2025 онд	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль MNS5916:2008 MNS5917:2008
2.	Биологийн нөхөн сэргээлт: БОНБНУ-ний дагуу, уурхайн хаалт 2032 онд хийгдэж эхлэх тул биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй. /Иймээс дүйцүүлэн нөхөн сэргээлт хийнэ./	1.Ажилчдын хотхон орчмын талбайд хөрсийг нөхөн сэргээж зүлэгжүүлж, цэцгийн мандал, мод, бут тарина.	га	1	1.0	1.0	2025 оны 5,10-р сард	Аймгийн ИТХ-ийн 2015 оны 04 сарын 56 дугаар тогтоолоор батлагдсан “1 тонн баялаг- 1 мод хөтөлбөр” MNS5917:2008 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн
		2.Уурхайн талбайд тарьсан мод бут уулын ахилт, тэлэлтэд өртөж болзошгүй мод бутыг шилжүүлэн суулгах.	га	1	2.0	2.0	2025 оны 5,10-р сард	
		3.“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт 10 га газар 15000ш заг мод тарьж ургуулах	га	10	35.0	35.0	2025 онд	
		4.“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ажилчдын хотхоны мод үржүүлгийн талбайд тарьсан мод бут шилжүүлэн тарих, үрээр нэмж тарих.	га	0.2	1.0	1.0	2025 онд	

		5.“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ажилчдын хотхоны мод үржүүлгийн талбайд ургасан болон Гурвантэс сумаас модны үр түүж бэлтгэх.	кг	8	-	-	2025 онд	
		6.“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд гарсан бодлого шийдвэрийг дэмжин ажиллах бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилогч мод, бутны үрийг түүж бэлдэх, тарих, туршилт судалгаа явуулж тарьц суулгацын нөөц бүрдүүлнэ.	га	1	3.0	3.0	2025 онд	
3.	Татан буулгах, хаалгад бэлтгэх:	1.Хуулсан шимт хөрсийг хадгалах, төслийн үйл ажиллагаа дууссаны дараа хөрсийг бүтцийн дагуу дахин хучиж сэргээнэ. Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хадгалах	га	1	0.2	0.2	2025 онд	MNS5917:2008
	Нийт					43.6		


3.1 Техникийн нөхөн сэргээлт

ТЭЗҮ болон БОНБНҮ-ний дагуу, уурхайн хаалт 2032 онд хийгдэж эхлэх тул техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

3.1.1 Овоолгын талбай тэлэх үед үржил шимт хөрсийг хуулан авч нөхөн сэргээлтэд хэрэглэхээр хадгална. Хуулсан шимт хөрсийг овоолго хийж стандартын дагуу бүтцийг нь алдагдуулахгүй хадгалах арга хэмжээ авна.

Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу ордын ТЭЗҮ болон БОНБНҮ –ний тайланд тусгаснаар үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт хамгаалалт болон хэлбэржүүлэх ажлыг хийсэн бөгөөд салхинд хийсэж чийг үржил шимээ алдахаас сэргийлж карьераас ус, мөс зөөн авчран байнгын усалж чийглэж байсан. Хүрэн толгойн уурхайн жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөнд оруулан гүйцэтгэж байна.

Хүрэн толгойн уурхайн ашиглалтын явцад 90000м³ шимт хөрс хуулж хадгалж байгаа бөгөөд шимт хөрсний овоолгыг хэлбэржүүлэн засах ажлыг жил бүр хийдэг. 2025 онд 31526 м³ шимт хөрс хэлбэржүүлэх, овоолох талбайг хуурайшиж салхинд хийсэхээс хамгаалж ажилласан.



Зураг 34 ХТКМ шимт хөрсний овоолго

3.2 Биологийн нөхөн сэргээлт:

3.2.1 Ажилчдын хотхон орчмын талбайд хөрсийг нөхөн сэргээж зүлэгжүүлж, цэцгийн мандал, мод, бут тарина.

Орчны тохижилт, ногоон байгууламж

2012 онд уурхайн шинэ ажилчдын байр, оффис, нийтийн хоолны газар зэрэг барилга байгууламж ашиглалтад орсон бөгөөд эдгээр барилга байгууламж ашиглалтад орсноор ажилчдын ажиллаж, амьдрах нөхцөл сайжирч, ая тухтай орчныг нь бүрдүүлэхэд анхаарч ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

2025 оны байдлаар ажилчдын ажиллаж амьдрах тохитой орчныг бий болгох дараах бүтээлч ажлыг үргэлжлүүлэн зүлэгжүүлэх, цэцэг, мод, тарих ажлыг хийсээр байгаа бөгөөд уурхайн хотхоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд хаврын тарилтаар мод, цэцгийн мандал болон, усалгааны систем шинэчлэл засвар зэрэг ногоон байгууламжаа сайжруулах, нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна.



Зураг 35 Оффис гаднах орчин

Орчны ногоон байгууламжийг сайжруулах ажлын хүрээнд 1120 м² газрыг хагалж бэлтгэн говийн нөхцөлд ургадаг ерхөг, өлөнгө зүлэг тарьж арчлан ургуулсан 36 м² цэцгийн мандалд цинния, бархатцы хилэн цэцгийн үрүүдийг суулган ургуулсан.



Зураг 36 Цэцэгт ургамал тарилт

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 193 дугаар тогтоолоор жил бүрийн тав болон аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гарагийг “Бүх нийтээр мод тарих өдөр” болгон тэмдэглэж байхаар тогтоосон байдаг. Энэхүү өдөр нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрийн байгаль хамгаалах ухамсар, орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх үйлсэд идэвхтэй оролцоог дэмжих зорилгоор уурхайн ойр орчимд 4 төрөл зүйлийн 800ш мод бутыг тарих ажлыг уурхайн нийт ажилчдыг хамруулан тус ажлыг зохион байгуулсан. Мөн шинээр тарьсан моднуудыг хөрсний чийг, цаг уурын нөхцөлд тохируулан гүйцэтгэж, тарьц суулгацын амьдралтын хувь, ургалтын хяналт, арчилгаа, усалгааны ажлыг тогтмол хийж байна.



Зураг 37 Хаврын мод тариалалт

3.2.2 Уурхайн талбайд тарьсан мод бут уулын ахилт, тэлэлтэд өртөж болзошгүй мод бутыг шилжүүлэн суулгах

Засвар үйлчилгээний төвийн задгай агуулахын талбай барихтай холбоотойгоор ахилтад өртсөн 150 ш жигд мод, бут сөөгийг шилжүүлэн суулгах ажлыг зохион байгуулсан. Уг моддыг “Хүрэн Толгой” уурхайн амрах хотхоны хойд хэсэгт нөхөн тарьж, шилжүүлэн суулгалт хийсэн байна.



Зураг 38 Мод шилжүүлэн суулгах явц

3.2.3 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт 10га газар 15000ш заг мод тарьж ургуулах

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд, Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Гурвантэс сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниуд хамтран 10 га талбайд 10000ш заг модоор ойжуулалын ажлыг хийж хашиж хамгаалан, инженерийн хийцэл бүхий худаг гарган усалгааны систем суурилуулан 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаа. Тус ажил нь нутгийн хөрсний онцлогт тохирсон загийн суулгацыг ашиглан ойжуулалт хийж, нөхөн сэргээлтийн талбайн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, цөлжилтийн үйл явцыг сааруулах, орон нутгийн байгалийн унаган төрхийг сэргээх онцлог ажил болсон юм.



Зураг 39 Заг мод тарих талбай

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ойжуулалтын ажлын талбай нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Гоёот багийн нутагт, Хүрэн толгой уурхайгаас ойролцоогоор 85 км, сумын төвөөс 40 км зайд, Давсны үйлдвэрийн баруун хойд талд байрлана.

Ойжуулалтын талбайн GPS солбицол дараах байршлуудад хамаарна:

- 707647.35 E, 4810424.51 N
- 707990.70 E, 4810446.21 N
- 707992.01 E, 4810139.75 N
- 707676.26 E, 4810121.34 N

Энэхүү бүс нутаг нь говийн цөлжүү хээрийн бүсэд хамаарах бөгөөд жилийн дундаж хур тунадасны хэмжээ 70–150 мм, зарим хуурай жилүүдэд 40–60 мм буюу түүнээс бага байдаг онцлогтой. Иймд тарьсан заганы модны ургалтыг тогтворжуулах зорилгоор 1–2 жилийн хугацаанд тогтмол усалгаа, арчилгаа, мөн мал амьтнаас хамгаалан хашаалах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Зураг 40 Заг мод тарих ажлын үйл явц

Ойжуулалтын талбайд модны тогтвортой ургалтыг хангах үүднээс 30 тн багтаамжтай усны нөөцийн савыг зөөж байрлуулж, мод усалгааны үндсэн хоолойтой холбосон. Усны түгээх дуслын хоолойг цоолж, насосны холболтыг хийсэн бөгөөд нийт 24,000 метр PE дуслын хоолойг суурилуулж, 15,000 ш модны дуслын хошуу байрлуулан мод усалгааг гүйцэтгэжээ.

Усалгааны системд 1.1 кВт шугамын насосыг тоноглож, усны нөөцийн савнаас дуслын хоолойд шахаж модыг тогтмол услахад ашигласан. Мөн системийг нарны эрчим хүчээр ажиллуулах үүднээс 5 кВт хүчин чадалтай нарны цахилгаан үүсгүүрийг суурилуулан ажиллагаанд оруулсан байна.



Зураг 41 Нарны цахилгаан үүсгүүр

Заг модны тарьц суулгах ажлыг нийт 27 хоногийн хугацаанд компанийн 1 болон 2-р ээлжийн 26 ажилтан оролцон, өөрийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд нийт 266,646,527 төгрөг зарцуулж, 15,000 ширхэг заг мод тарих, мөн усалгааны систем болон цахилгаан эх үүсвэрийн угсралт, холболтын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Тарьсан заг моддын усалгаа, арчилгааг нутгийн иргэн хариуцан гүйцэтгэж, тогтмол усалгаа, арчилгааг хуваарийн дагуу хийж байна.



Зураг 42 Заг мод тарьсан 10 га талбай

3.2.4 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ажилчдын хотхоны мод үржүүлгийн талбайд тарьсан мод бут шилжүүлэн тарих, үрээр нэмж тарих

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2023–2024 онд мод үржүүлгийн талбайд ургуулсан нийт 2,610 ширхэг хайлаас модыг шилжүүлэн тарьж, нөхөн сэргээлт болон ногоон байгууламжийн ажлыг зохион байгуулсан.

Тарьц, шилжүүлэн суулгалтыг дараах байршлуудад хийсэн байна

- Ажилчдын хотхон – 2,060 ширхэг хайлаас мод;
- Кемпийн урд дагуу нөхөн тариалт – 300 ширхэг хайлаас мод;
- “Хонингийн булаг” 2024 онд хамгаалсан талбайд – 250 ширхэг хайлаас мод тус тус шилжүүлэн тарьсан.

Ингэснээр уурхайн орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлж, тоосжилт бууруулах, бичил уур амьсгалыг сайжруулах зорилтот ажлыг амжилттай хэрэгжүүлсэн.



Зураг 43 Хонингийн булаг

3.2.5 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ажилчдын хотхоны мод үржүүлгийн талбайд ургасан болон Гурвантэс сумаас модны үр түүж бэлтгэх.

“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ажилчдын хотхонд байрлах мод үржүүлгийн талбайд ургасан жигд, хайлаас, агч болон заг модноос нийт 20кг үр түүж, бэлтгэсэн. Бэлтгэсэн үрийг цаашид үрслэг бэлтгэх, мод үржүүлгийн ажлыг өргөжүүлэх, нөхөн сэргээлт болон ногоон байгууламжийн ажилд ашиглах зорилгоор хүлэмжид тариалалт хийсэн.



Зураг 44 Модны үр

3.2.6 “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд гарсан бодлого шийдвэрийг дэмжин ажиллах бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилогч мод, бутны үрийг түүж бэлдэх, тарих, туршилт судалгаа явуулж тарьц суулгацын нөөц бүрдүүлнэ.

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд гарсан бодлого, шийдвэрийг дэмжин ажиллаж байна. Тухайн бүс нутгийн байгаль, цаг уур, хөрсний онцлогт тохирсон мод, ургамлын төрөл зүйл

болох хайлаас, агч, жигд зэрэг модны үрийг бэлтгэх, соёолуулах, тарих ажлыг төлөвлөж, туршилт, судалгааны ажлуудыг зохион байгуулан ажилласан.



Зураг 45 Хүлэмжинд тарилт хийсэн байдал

3.3 Татан буулгах, хаалтад бэлтгэх

3.3.1 Хуулсан шимт хөрсийг хадгалах, төслийн үйл ажиллагаа дууссаны дараа хөрсийг бүтцийн дагуу дахин хучиж сэргээнэ. Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хадгалах



Хүрэн толгой уурхай шимт хөрсний 3 овоолго үүсгэж 34936 м² талбайд, 31625 м³ хөрс хадгалалт болон хэлбэржүүлэлтийг MNS 5916:2008 стандартын дагуу хийсэн.

Зураг 46 Шимт хөрсний овоолго

4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Зорилго: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн 8.4.6. заалтын дагуу Нарийн сухайтын уурхайн бүлэг ордод үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад учруулж байгаа байгаль орчны сөрөг нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулах

2017 онд “Чандлан” ХХК-иар тус ажлыг гүйцэтгүүлж “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний судалгааны тайлан” – г Өмнөговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт болон Гурвантэс сумын ЗДТГазарт хүргүүлж, танилцуулсан. 2019 онд “GREEN TRENDS” ХХК-тай гэрээ байгуулж “Хөхөлзөхийн говь”-д судалгааны ажил хийлгэсэн. Судалгааны ажлын тайлан 2020 онд хүлээн авсан бөгөөд тайланд тусгагдсан зөвлөмж, төлөвлөгөөг баримтлан ажилласан.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8
1.	Тухайн сонгон авсан талбайд амьтдын амьдрах орчинг сайжруулах	1.Уурхайн ойр орчмын ургамал, хар сүүлт түүний амьдрах орчин бусад зүйлийн амьтдын тоо толгойн мониторинг судалгаа хийж бүртгэж байх.	Хөхөлзөхийн говь,	4	0.25	1.0	2025 онд	БОННУ-ний аргачлал, Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын судалгааны үр дүн
		2.Талын пост хэмээх газар зэрлэг ан амьтанд зориулсан инженерийн хийц бүхий уст цэг 2021 онд байгуулсан түүний хэвийн ажиллагаа болон зэрлэг амьтад ундалж байгаа зэрэгт хараа хяналт тавих	Хөхөлзөхийн Сархиа 3080 га талбайд, Уурхай орчимд	2	0.5	1.0	2025 онд	
		3.Төсөл хэрэгжих хугацаанд ган, зуд ихтэй жилүүдэд зэрлэг ан амьтдын идэш тэжээлийг бэлдэх биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.		3	1.0	3.0	2025 онд	


2.	Байгаль орчныг хамгаалах	1.Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан сургуулийн хүүхдүүд болон иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Гурвантэс сум	3	1.5	4.5	2025 онд	Байгаль орчны тэмдэглэлт өдөр
		2.Орон нутгийн иргэд болон орон нутгийн захиргаанаас санал болгосон тус бүс нутагт хамгаалах шаардлагтай байгаа булгийн эхийг сэргээж хөв байгуулах		1	5.0	5.0	2025 онд	Өмнөговь аймгийн байгаль орчны газраас ирүүлсэн зөвлөмж
		3.Тоорой судалгаанд үндэслэн баянбүрдийг хамгаалах, ундаргыг нэмэгдүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх,		1	11.5	11.5	2025 онд	
		4.Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан багийг ажиллуулах, хамтран ажиллах.		1	1.0	4.0	2025 онд	Амьтны тухай хууль
Нийт зардал						30.0		

4.1 Тухайн сонгон авсан талбайд амьтдын амьдрах орчныг сайжруулах

4.1.1 Уурхайн ойр орчмын ургамал, хар сүүлт түүний амьдрах орчин бусад зүйлийн амьтдын тоо толгойн мониторинг судалгаа хийж бүртгэж байх.

Уурхайн орчимд амьтны мониторингийн судалгааг улирал бүр “Нарийн сухайтын уурхай” болон “Бласт” ХХК-тай хамтран Баруун Сухант, Зүүн Сухант, Нүдэн булаг, Ямаат уул, уст цэгүүд, уурхайн баруун тал болон Ногоон чулууны булаг орчмоор нийт 198 км замд хийж гүйцэтгэдэг. Судалгааны явцад нийт 54 бодгаль амьтан ажиглагдсан байна. Цаашид хамтарсан судалгааг улирал бүр давтамжтайгаар зохион байгуулж, хээрийн судалгаагаар ан амьтны тоо толгойг дахин бүртгэн, хамгааллын чиглэлээр авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Уурхайн нөлөөллийн бүсэд амьтны судалгаа хийснээр уурхайн үйл ажиллагаанаас үүдэх ан амьтдын амьдрах орчны өөрчлөлт, нүүдлийн замнал, тоо толгойн хэлбэлзлийг тодорхойлох зорилготой юм.



Зураг 47 Судалгаа хийсэн байршил

Хүснэгт 3 Судалгааны үед тааралдсан амьтны байршил, тоо толгой

№	Нэршил	Газрын нэр	Газар зүйн байршил	Тоо хэмжээ
1	Хар сүүлт	Ногоон чулууны булаг	42°56'02.72"N	4
			101°04'58.16"E	
2	Тас	Ногоон чулууны булаг	42°56'00.22"N	2
			101°04'58.16"E	
3	Хар сүүлт	Ногоон чулууны булаг орчим	42°56'00.22"N	2
			101°04'58.16"E	
4	Хар сүүлт	Ногоон чулууны булаг орчим	42°58'25.72"N	2




			101°04'49.16"E	
5	Хар сүүлт	Хайлаастын хавцал орох замд	43°01'17.04"N	2
			101°04'11.60"E	
6	Хар сүүлт	Хайлаастын хавцал орох замд	43°01'16.58"N	5
			101°03'45.91"E	
7	Хар сүүлт	Хайлаастын хавцал орох замд	43°03'13.46"N	2
			101°04'20.08"E	
8	Хар сүүлт	Хайлаастын хавцал орох замд	43°04'22.42"N	2
			101°05'21.32"E	
9	Хар сүүлт	Хайлаастын хавцал орох замд	43°07'32.52"N	2
			101°04'36.07"E	
10	Хар сүүлт	Хайлаастын хавцал	43°12'55.68"N	2
			101°07'68.36"E	
11	Хар сүүлт	Их хонгил	43°27'00.41"N	4
			101°05'00.08"E	
12	Аалз	Ямаат уул	43°14'09.77"N	1
			101°11'02.49"E	
13	Тас	Ямаат уул	N42°56'03.69	1
			E101°19'03.60	
14	Хар сүүлт	Хавцал	N43°07'07.63	5
			E101°01'46.57	
15	Хазуулагч шувуу	Нүдэн булаг	N43°07'07.63	1
			E101°01'46.57	
16	Ангир	Баруун сухант	N43°05'54.49	16
			E101°04'59.25	
17	Үнэг	Амрах хотхон	N43°00'49.08	1
			E101°14'26.11	
НИЙТ ДҮН				54

Хүснэгт 4 Гадаад орчны үзүүлэлтүүд

№	Байршил	Гадаад орчны үзүүлэлтүүд	
		Салхины дундаж хурд м/сек	Температур, °C
1	Ногоон чулууны булаг	0.3 м/сек	9°C
2	Хайлаастын хавцал	0.2 м/сек	9°C

3	Их хонгил	1.2 м/сек	11.9°C
4	Ямаат уул	2.5 м/сек	14.2°C

Хүснэгт 5 Судалгааны ажилд шаардлагатай тоног төхөөрөмжүүд

№	Хэмжилт хийсэн төрөл	Хэмжилт хийсэн багаж, нэр	Хэмжилт хийсэн багаж	
1	Гадаад орчны хэмжилт	Environmental-meter		
2				Салхины хурд
3				Орчны гэрэлтүүлэг
4				Агаарын дундаж чийгшил
5				Дуу чимээ
6	Усан орчин	PH-meter		
7				Температур
8	Хөрс	Soil survey instrument		
9				Температур
10	Амьтаны тоо толгойн бүртгэл	<ol style="list-style-type: none"> 1. нүдний дуран 2. Байршил тогтоогч gps 3. Замналын судалгааны нэгдсэн хүснэгт 		





Зураг 48 Судалгааны үед тааралдсан амьтад

4.1.2 Талын пост хэмээх газар зэрлэг ан амьтдын зориулсан инженерийн хийц бүхий уст цэг 2021 онд байгуулагдсан түүний хэвийн ажиллагаа болон зэрлэг ан амьтан ундаалж байгаа зэрэгт хяналт тавих

Хөхөлзөхийн говийн “Талын пост” гэх газар байгуулсан зэрлэг ан амьтанд зориулсан автомат уст цэгийн хэвийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 2025 оны 4-р сар болон 10-р сард цэвэрлэгээ, үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 49 Хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж буй байдал

4.1.3 Төсөл хэрэгжих хугацаанд гам, зуд ихтэй жилүүдэд зэрлэг ан амьтдын идэш тэжээлийг бэлдэх биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Тост-Тосон Бумбын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаа болон Тост багийн идэвхтэн байгаль хамгаалагч нартай хамтран Тосон Бумбын нурууны хамгаалалттай газар нутагт биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай өвс тэжээлийн захиалга хийсэн ба өвс тэжээлийг ирхээр 11-р сард Тос тосон бумбын нурууны Шар хөндий, Мөст орчим цастай гуу жалгаар зэрлэг ан амьтад зориулан тараан байршуулна.

ХА хүсэлт		Миний батлах хүсэлт		Хүсэлт		Миний хянах самбар		Миний захиалгууд		Тохиргоо				
Бүх хүсэлт / PR2510-28599														
Хэвлэх Үйлдэл 27 / 80 Шинэ														
ЦУЦЛАХ НООРОГ НЭГЖИЙН АЖИЛТАН ИЛГЭЭСЭН НЯГТЛАН ХЯНАСАН ХЯНАСАН ЗАХИРАЛ БАТАЛСАН ЦУЦЛАГДСАН														
Нэр PR2510-28599														
Урсгал тохиргоо	ХА хүсэлт-ХТКМ			Салбар	Хүрэн Толгой Коал Майнинг ХХК									
Агуулах	[ХМ-ЧМ] Хангамжийн материал - ХТКМ - Хангамж			Урьдчилсан захиалсан огноо	2025-10-03									
Ажилтан	Д.ТЭГШДЭЛГЭР [6711] Хангамжийн мэргэжилтэн			Авахаар төлөвлөсөн огноо	2025-10-31									
Хариуцагч	Д.ТЭГШДЭЛГЭР [6711] Хангамжийн мэргэжилтэн			Нийлүүлэх огноо										
Эзэргэлэл	Энгийн /15-30/			Батлагдсан огноо	2025-10-10 11:04:57									
Хэлтэс	Захиргаа, хүний нөөцийн хэсэг [ХТКМ--ЭХН]			Батлах хярилагчид										
Сектор	Хүрэн Толгой Коал Майнинг ХХК			Буцаалтын тайлбар										
Компани	Хүрэн Толгой Коал Майнинг ХХК			Төсөл сонгох	<input type="checkbox"/>									
Тайлбар зориулалт	Өвс захиалга /БОМТ-ний дагуу /			Төлөвлөгөөт эсэх	<input checked="" type="checkbox"/>									
Үнэ ашиглах	<input type="checkbox"/>			Төлөвлөгөө	ХТКМ - 2025 ХАТ									
				Жилийн захиалга	<input type="checkbox"/>									
				Төлөвлөгөөт сар	8 сар									
				Хөрөнгө оруулалт	<input type="checkbox"/>									
				Ажлын даалгавар										
Баруунд Өмнөх захиалгын түүх Худалдан авалтын захиалгууд Төлийн Түүх														
#	Бараа	Эдийн дуга...	Тайлба...	Хэмжих нэ...	Ангилал	Төлөөл...	Төлөөл...	Тайлба...	Үлдэгдэл	Эргэц	Хэд хон...	Нийлүү...	Тоо хэм...	Төлөв
1	{10000014} ө...		өвс	ширээг	Аж ахуйн ма...	өвс	2,500.00		0.00	0.00	0.00	12.78	1,000.00	Харьцуу

Зураг 50 Биотехникийн арга хэмжээ захиалга

4.2 Байгаль орчныг хамгаалах

4.2.1 Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан сургуулийн хүүхдүүд болон иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

Хүрэн толгой уурхай нь нийгмийн хариуцлагын хүрээнд Гурвантэс сумын Ерөнхий боловсролын сургууль болон Засаг даргын Тамгын газартай хамтран “Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан сурагчдын дунд усны нөөцийг хамгаалах, байгаль орчны үнэ цэнийг ойлгуулах зорилготой дараах уралдаан, тэмцээнүүдийг зохион байгууллаа. Үүнд:

- Ахлах ангийн сурагчдын дунд “Дэвжээ” тэмцээн,
- Дунд ангийн сурагчдын дунд багийн “Алтан хонх” тэмцээн,
- Бага ангийн сурагчдын дунд “Ил захидлын уралдаан” тус тус зохион байгуулсан.

Эдгээр арга хэмжээ нь сурагчдын байгаль хамгааллын мэдлэгийг нэмэгдүүлэх, усны нөөцийг хайрлан хамгаалах дадлыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн юм.






Зураг 51 Дэлхийн усны өдөр зохион байгуулсан

4.2.2 Орон нутгийн иргэд болон орон нутгийн захиргаанаас санал болгосон тус бүс нутагт хамгаалах шаардлагатай байгаа булгийн эхийг сэргээж хөв байгуулах.

Гурвантэс сумын Байгаль орчны байцаагчийн 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн тогтоолын дагуу тус бүс нутагт хамгаалах шаардлагатай гэж үзсэн булгийн эхийн байршлыг тодорхойлсон. Уг булгийн эх нь Хүрэн толгой уурхайн төв цэгээс 105 км зайд оршдог бөгөөд байгаль орчны хамгаалалт, усны нөөцийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хамгаалалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.



Зураг 52 Талбайн байршил

4.2.3 Тооройн судалгаанд үндэслэн баянбүрдийг хамгаалах, ундаргыг нэмэгдүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх

МАК Нарийн сухайтын уурхайтай хамтран Зүүн Сухантын нутагт байрлах “Баян Тоорой” хэмээх газарт 3.4 га талбайд 750 метр урт хамгаалалтын хашаа барин, тоорой моддыг хамгаалах ажил хийж хэрэгжүүлсэн.

“Баян Тоорой” нь Говийн хуурай бүсийн экосистемд ховор тохиолддог модлог ургамлын нэг болох тоорой (*Populus diversifolia*) ургадаг бүс юм. Тоорой мод нь говийн хатуу ширүүн нөхцөлд ургаж, хөрсний чийг хадгалах, шороон шуурга болон хөрсний элэгдлээс хамгаалах, орчны бичил экосистемийг тэтгэх чухал үүрэгтэй.

Гэвч тоорой мод (*Populus diversifolia*) нь устах аюулд орсон, нэн ховор ургамлын төрөл зүйл бөгөөд Монгол Улсын Улаан ном болон Олон улсын Байгаль хамгаалах холбоо (IUCN)-ын ховордсон зүйлсийн жагсаалтад бүртгэгдсэн байдаг. Сүүлийн жилүүдэд байгаль орчны доройтол, бэлчээрийн даац хэтрэлт, усны түвшин бууралт, хөрсний элэгдэл, хүний үйл ажиллагааны нөлөө зэрэг хүчин зүйлсийн улмаас түүний тархалтын бүс эрс хумигдаж, нөхөн сэргэх чадвар буурч байна. Иймд тоорой модыг хамгаалах, үрийн нөөцийг хадгалах, нөхөн сэргээх арга хэмжээг цаашид ч гэсэн авч хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.



Зураг 53 Тоорой мод хашсан байдал

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь МУ-005459 Тусгай зөвшөөрлийн 70.47 га уурхайн эдэлбэр газар болон бусад хэлбэрийн газрыг зохих зөвшөөрлийн дагуу ашиглаж байна. Компани нь 2003 оны 03-р сараас үйл ажиллагаа явуулж ашигт малтмалын орд ашиглах 5459А дугаарын лиценз эзэмших талбайд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 4-р багийн малчин Лувсан овогтой Баярсайханы эзэмшил болох Нарийн сухайтын Шандын өвөлжөө, Хөх толгой, Хөөврийн хаваржаа орсон байна. Иймд манай компани нь МУ-ын газрын тухай хуулийн 56-р зүйлийн 2,3 иргэний хуулийн 110, 113-р зүйл Гурвантэс сумын ЗДТГ-тай харилцан тохиролцож хүлээсэн үүргийн дагуу малчин Л.Баярсайханы өвөлжөө бууцыг нүүлгэн шилжүүлж шинээр сэргээн барьж байгуулсан. 2025 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь 2005 онд Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Тогтвортой байдлын гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт БНХАУ-ын Сэхээ-Монгол улсын Шивээхүрэн боомт Нарийн сухайтын уурхай хүртэл 56 км хатуу хучилттай зам барих тусгай зөвшөөрлийг Зам тээвэр, Аялал жуулчлалын Яамнаас авч, замын барилга байгууламжийн ажлыг эхэлжээ.

Тус хүрээлэнгийн судалгааны баг Монгол улсын “Соёлын Өвийг хамгаалах тухай” хуулийн 6-р бүлгийн 17-гийн 10-т заасны дагуу нүүрсний ордыг ашиглах төслийн хүрээнд хатуу хучилттай авто зам барих газарт 2007 оны 10-р сарын 23-наас 31ны хүртэл 7 хоногийн хугацаатай археологийн урьдчилсан хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ судалгааны ажлын хүрээнд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс тохиолдоогүй болно.

Өмнөговь аймгийн Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулдаг “Хүрэн толгой коал майнинг” ХХК нь орон нутгийн соёл, уламжлалт мал аж ахуйг дэмжих зорилгоор говийн бахархал болсон хоёр бөхт тэмээн сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх, амьдын үнэлэмжийг дээшлүүлэх, тэмээний сүү, сүүн болон ноос, ноосон бүтээгдэхүүний онцлог, давуу талыг олон нийтэд сурталчлан таниулах, залуу тэмээчдийг урамшуулах чиглэлээр ажиллаж байна.

Эдгээр зорилгын хүрээнд 2005 оноос хойш жил бүр компанийн нэрэмжит “Тэмээн сүргийн баяр” арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагаанд нийт 145.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд, орон нутгийн түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Тэмээн сүргийн баяр”-ын 19 дэх удаагийн арга хэмжээг 2025 оны 1 дүгээр сарын 17–18-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.

Энэ удаагийн арга хэмжээг нийт 19.974.000 төгрөгийн төсвөөр хэрэгжүүлсэн бөгөөд тэмээний аж ахуй, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, малын уралдааны чиглэлээр амжилт гаргасан малчид, уяачид болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарыг шалгаруулж, шагнаж урамшуулсан байна. Тус арга хэмжээ нь орон нутгийн малчдын хөдөлмөрийг үнэлэх, уламжлалт мэдлэг, ур чадварыг хадгалах, говийн бүсийн нийгэм, соёлын үнэт өвийг хамгаалан өвлүүлэхэд чиглэж байгаа юм.



ТЭМЭЭЧДИЙН БАЯР-2025

ХӨТӨЛБӨР

2025 оны 01 сарын 17-ны өдөр	2025 оны 01 сарын 18-ны өдөр
10:00 цагт - Үзэсгэлэн худалдаа	07:00-09:00цагт - Бүдүүн тэмээний уралдаан
17:00 цагт- Тэмээчдийн техникийн зөвлөгөөн	10:00-11:00 цагт - Тайлаг тэмээний уралдаан
17:30 цагт- Хурдан тэмээний бүртгэл	11:00-11:30 цагт - Тэмээчдийн баяр 2025" нээлтийн үйл ажиллагаа /Төв цэнгэлдэхэд/
20:00цагт- Тэмээний тухай магтаал хэн сайн хэлэх өз /тэмцээн /	11:30-12:30 цагт - Ботгон торомны уралдаан
*Үдшийн цэнгүүн	12:30- 13:30цагт - Богино зайн уралдаан
	Шилмэл буур ингэ шалгаруулах
	13:30-14:30цагт - Сайхан хэрэгсэлтэй Ат шалгаруулах
	Тэмээтэй сайхан хос шалгаруулах
	15:00-16:00 цагт - Шагнал гардуулах
	16:00 цагаас Хаалтын үйл ажиллагаа

Зураг 54 Тэмээчдийн баяр 2025 хөтөлбөр

“Тэмээн сүргийн баяр 2025”

Энэхүү арга хэмжээг зохин байгуулснаар тухайн ард түмний үндэстний оюун санаагаар бүтэж, уламжлагдан ирсэн түүхэн тодорхой орон зайг төлөөлж чадах эх хэл, ардын мэдлэг, амьдрах арга ухаан, байгаль ертөнцийн тухай мэдлэг, хөдөлмөрийн зан үйл, наадам наргиа, ёс заншил, дуу хөгжим, уламжлалт гар урлал, түүний ур хийц, технологи зэрэг соёлын орон зайг бий болгосон юм.



Зураг 55 Тэмээчдийн баяр 2025

Сүү, сүүн бүтээгдэхүүний ашиг шим, чанар, үнэлэмжийг дээшлүүлэх, үндэсний гар урлалын уламжлалт бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдааны үеэр орон нутгийн малчид, үйлдвэрлэгчид, гар урлалын уран бүтээлчид өөрсдийн бүтээгдэхүүнээ танилцуулж, “Шилдэг цагаан идээ” болон “Шилдэг гар урлал” ангиллаар шилдгүүдийг шалгаруулан шагнаж урамшуулсан.





Зураг 56 “Тэмээн сүргийн баяр 2025” үзэсгэлэн худалдаа

Монгол ардын аман яруу найргийн уламжлалт, өвөрмөц нэгэн төрөл болох магтаал нь байгаль, амьтан, хүн, хөдөлмөрийн сайхан шинж чанарыг дүрслэн бахархан өгүүлэх урлагийн хэлбэр юм. Уламжлалт соёлын өвийг хадгалж хамгаалах, ард түмэнд түгээн таниулах зорилгоор тэмээний магтаалын уралдаан зохион байгуулж, тэмээний сайн шинж, ач тус, говийн бахархал болсон тэмээн сүргийн үнэ цэнийг илэрхийлэн магтсан бүтээлүүдийг хүргэсэн.



Зураг 57 “Тэмээн сүргийн баяр 2025” тэмээний магтаал

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	1.Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан уурхайлалтыг хүрээлэн буй орчин болон хүн малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатайгаар зохицуулан ажиллах	Төслийн хүрээнд	-	Үйлдвэрлэлийн зардал		Үйл ажиллагааны турш	Компанийн онцгой байдлын үед ажиллах төвөвлөгөө
		2.Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахуудыг гадаргын урсаас хамгаалах ба тэдгээрээс бохирдол зөөгдөхөөс хамгаалсан далан шуудуу засаж сэргээх	ШТС, засварын талбай	-			Үйл ажиллагааны турш, тогтмол хугацаагаар	БН ба дүрэм
		3.Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн хүрээнд, ШТС	-			Үйл ажиллагааны турш, тогтмол хугацаагаар	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS5566:2008 MNS0640:89 MNS639:89
		4.Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Төслийн хүрээнд, ШТС	-				
2.	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл	1.Үйлдвэрлэлд гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж мөрдөх	Төслийн хүрээнд	-	Үйлдвэрлэлийн зардал		Үйл ажиллагааны турш	MNS4990:2000 MNS4969:2000
		2.Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн хүрээнд	-				

	ажиллагаа доголдох, зогсох	3.Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Төслийн хүрээнд	-	Хөдөлмөр хамгааллын зардал		
		4.Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэрэгслээр хангах	Төслийн хүрээнд	-			
		5. Ажилд гарахын өмнө эмчийн үзлэгт бүх ажиллагсдыг хамруулах;	Төслийн хүрээнд	-			
		6.Гал унтраах багаж хэрэгслээр иж бүрэн хангах, шаардлагатай газарт байрлуулах, зориулалтын дагуу ашиглах, холбогдох хүмүүс тэдгээрийг ашиглах арга ажиллагаанд суралцсан байх;	Төслийн хүрээнд, ШТС	-	Үйлдвэрлэлийн зардал		
3.	Шатах тослох материалын сөрөг нөлөөлөл	1.Галын багаж, хэрэгсэл авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгаж, сэлбэж байх.	Төслийн хүрээнд, ШТС	-	Үйлдвэрлэлийн зардал	ШТС техникийн ерөнхий шаардлага	
		2.Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах.	ШТС	-			Үйл ажиллагааны турш
		3.Шатах тослох материалын хор аюулын талаар сургалт явуулах.	Уурхайн нийт ажилчид	-			
		4.ШТС-ын аюулгүй байдал, бүрэн бүтэн байлгах үүднээс харуул хамгаалалтын ажилтан байнгын байрлах.	ШТС				

		5.Шатах тослох материал ачиж буулгах, цэнэглэх хэсэгт асгарсан тохиолдолд хөрсөнд нэвчүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Төслийн хүрээнд, ШТС	-			
	Нийт				-	-	-

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

7.1. Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах

7.1.1 Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан уурхайлалтыг хүрээлэн буй орчин болон хүн малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатайгаар зохицуулан ажиллах

Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд үндэслэн уурхайн үйл ажиллагааг хүрээлэн буй орчин болон хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөө багатайгаар зохицуулан явуулж байна. Байгалийн аюулт үзэгдэл гарсан тохиолдолд “Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г баримтлан ажиллах бөгөөд 2025 онд байгалийн аюулт үзэгдэл тохиолдоогүй болно.

7.1.2 Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахуудыг гадаргын урсаас хамгаалах ба тэдгээрээс бохирдол зөөгдөхөөс хамгаалсан далан шуудуу засаж сэргээх

Ашиглалтын явцад хөрсний бохирдол үүсэх эрсдэлтэй материал (шатах тослох материал, химийн бодис, техник үйлчилгээний хаягдал зэрэг)-ыг зориулалтын бетон суурь бүхий хадгалах талбайд байрлуулж байна. Тус талбайг бүрэн бетонжуулж, бороо, цас зэрэг хур тунадасны нөлөөнөөс хамгаалахын тулд дээвэр хийж бүрхсэн. Ингэснээр газрын хөрсөнд тос, химийн бодис шүүрэх эрсдэлийг бууруулж, хөрсний бохирдлоос сэргийлэх нөхцөл бүрдсэн.

Одоогоор тус хадгалах талбай зориулалтын дагуу ашиглагдаж байгаа бөгөөд хяналт шалгалтын явцад хөрсний бохирдол илрээгүй.

7.1.3 Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах

Монгол Улсын Засгийн газрын 339 дүгээр тогтоолын хавсралтад заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг” практик сургалт хэлбэрээр зохион байгуулсан.

Тус сургалтыг дараах сэдвүүдийн хүрээнд зохион байгуулсан:

- Гал унтраах практик сургалт
- Бүлгүүдийн бэлэн байдлын сургалт
- Анхан шатны тусламжийн сургалт
- Дуут дохиогоор ажиллах сургалт






Зураг 58 Галын сургалт зохион байгуулж буй байдал

7.1.4 Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах

Сар бүр тогтмол уурхайн нийт галын хорны хэвийн ажиллагааг шалган бүртгэл хөтлөн ажиллаж байна. 2025 оны 10-р сарын 25-ний байдлаар:Кемп, Уурхайн объектууд, хүнд машин механизм болон тээврийн хэрэгсэлд 128 галын хор тус тус байна.



Зураг 59 Галын аюулгүй байдлын үзлэг

7.2 Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох

7.2.1 Үйлдвэрлэлд гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж мөрдөх

Үйлдвэрлэл, уурхайн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, болзошгүй аваар, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны үзлэг шалгалт болон техникийн бэлэн байдлын үнэлгээг улирал бүр тогтмол зохион байгуулж байна. Мөн ажлын байрны химийн болон физикийн хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээг хийж, илэрсэн зөрчил, эрсдэлд үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

№	Урьдчилан сэргийлэх арга	Хугацаа	Галын ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хийгдсэн	
			Илэрхий зөрчилгүй байдал	Аюул хэрэгжүүлэх арга хэмжээ
1.	УБ-104 амьсгалын системийн үйлдвэр	24.03.14		<ul style="list-style-type: none"> -Техникийн ажил үйлчилгээний өдөр тутмын үйлдвэрлэлд хяналт тавьж, болзошгүй аваар, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны үзлэг шалгалт болон техникийн бэлэн байдлын үнэлгээг улирал бүр тогтмол зохион байгуулж байна. -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох
2.	Экскаватор И70 (Я609)	24.03.14		<ul style="list-style-type: none"> -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох
3.	Экскаватор И70 (Я609)	24.03.14		<ul style="list-style-type: none"> -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох
4.	Утгуурт ашигч	24.03.14		<ul style="list-style-type: none"> -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох
5.	Экскаватор И70 (Я609)	24.03.14		<ul style="list-style-type: none"> -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох
6.	Экскаватор 385	24.03.14		<ul style="list-style-type: none"> -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох
4.	Утгуурт ашигч	24.03.14		<ul style="list-style-type: none"> -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох
5.	Экскаватор И70 (Я609)	24.03.14		<ul style="list-style-type: none"> -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох
6.	Экскаватор 385	24.03.14		<ul style="list-style-type: none"> -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох -Техникийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох

Зураг 60 Техникийн үзлэгийн хуудас

2024 онд “Хэлт Сэфти энд Фрий Воркплэйс” ХХК нь Хүрэн толгой уурхайн нийт 28 ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхээр төлөвлөсөн. Үүнээс 24 ажлын байранд хэмжилт, үнэлгээний ажлыг төлөвлөгөөний дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн байна. Харин гэнэтийн эвдрэл, гэмтлийн улмаас 4 ажлын байранд тухайн үед хэмжилт хийгдээгүй үлдсэн. Үлдэгдэл 4 ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2025 оны 3 дугаар сард хийж гүйцэтгэн, тайланг бүрэн хүлээн авсан.



Зураг 61 Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт хийсэн байдал

7.2.2 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих

Үйлдвэрлэлд гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол арга хэмжээ авч, компанийн хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) журам, заавар, стандартуудыг шинэчлэн боловсруулж, холбогдох удирдлагаар батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн ажилтнуудын аюулгүй ажиллагааны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх соёлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, удирдамж, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж байна.

Хүснэгт 6 ХЭМАБ журмын жагсаалт

№	Журамын нэр	Батлагдсан огноо	Хуудасны тоо
1.	ХАБЭА-н сургалт орох, зааварчилгаа өгөх, шалгалт	2020.08.30	41
2.	Аюулыг мэдээллэх, зөрчлийг илрүүлэх журам	2020.08.30	11
3.	Эрсдэлийг үнэлэх, хянах журам	2020.08.30	13
4.	ХАБЭА-н зөвлөлийн ажиллах журам	2020.08.30	4
5.	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл хэрэглэх	2022.08.22	15
6.	ХАБЭА-н ажлын байрны үзлэгийн журам	2020.08.30	9
7.	Компанийн эзэмшлийн талбайд гэрээгээр ажил	2020.08.30	5
8.	Зөвшөөрлөөр ажил гүйцэтгэх журам	2020.08.30	12
9.	ҮО,ХХ,МШӨ-н үед авах арга хэмжээг зохицуулах	2020.08.30	15
10.	Радио станц ашиглах журам	2021.08.20	4
11.	Эмнэлэг, эрүүл ахуйн үйл ажиллагааны журам	2022.08.28	9

Хүснэгт 7 Аюулгүй ажиллагааны зааврын жагсаалт

№	Зааврын нэр	ААЗ	Хуудасны	Батлагдсан огноо
1.	Нийт ажиллагсдын мөрдөх ААЗ № 01	01	9	2021.08.16
2.	Компанийн цех хэсгүүдэд мөрдөх галын ААЗ №02	02	9	2021.08.16
3.	Аюул, осолд өртөгсөд үзүүлэх анхны тусламжийн	03	6	2021.08.16
4.	Үйлдвэр, уурхайгаар зорчих үед мөрдөх ААЗ № 04	04	4	2021.08.16
5.	Тэсэлгээний цооног өрөмдөх үед мөрдөх ААЗ № 05	05	9	2021.08.16
6.	Тэсэлгээ хийгдэх үеийн ААЗ № 06	06	4	2021.08.16
7.	Экскаваторын операторын мөрдөх ААЗ № 07	07	9	2021.08.16
8.	Автосамосвалын операторын мөрдөх ААЗ № 08	08	18	2021.08.16

9.	Автогрейдер, бульдозерын операторын мөрдөх ААЗ	09	8	2021.08.16
10.	Утгуурт ачигчийн операторын ААЗ № 10	10	18	2021.08.16
11.	Зам услах машинчийн мөрдөх ААЗ № 11	11	6	2021.08.16
12.	Засварчны мөрдөх ААЗ № 12	12	14	2021.08.16
13.	Дугуй засварчны мөрдөх ААЗ № 13	13	14	2021.08.16
14.	Машин механизм, техникүүдэд тосолгоо хийх үед	14	9	2021.08.16
15.	Ачаа оосорлох үед мөрдөх ААЗ № 15	15	7	2021.08.16
16.	Гар ба цахилгаан багажаар ажил гүйцэтгэх үеийн ААЗ	16	7	2021.08.16
17.	Цахилгааны засвар хийх үед мөрдөх ААЗ № 17	17	9	2021.08.16
18.	Цахилгаан хийн гагнуурын ажил гүйцэтгэх үеийн	18	9	2021.08.16
19.	Ачааг механизмаар өргөж, зөөх үед мөрдөх ААЗ № 19	19	8	2021.08.16
20.	Дизель мотор ажиллуулах үед мөрдөх ААЗ № 20	20	5	2021.08.16
21.	Гараар ачаа өргөх үеийн ААЗ № 21	21	7	2021.08.16
22.	Уурын зуух, галч ажилтны мөрдөх ААЗ № 22	22	5	2021.08.16
23.	Уурхайн гадна машин техникээр ажил гүйцэтгэх	23	5	2021.08.16
24.	Үйлчилгээний машины жолоочийн мөрдөх ААЗ № 24	24	5	2021.08.16
25.	Ажлын талбарт түлш цэнэглэх үеийн ААЗ № 25	25	8	2021.08.16
26.	Газар шорооны ажил гүйцэтгэх үеийн ААЗ № 26	26	3	2021.08.16
27.	Ирлэх суурь машин дээр ашиглах үеийн ААЗ № 27	27	5	2021.08.16
28.	Хүнс бараа материалын агуулахад мөрдөх ААЗ № 28	28	3	2021.08.16
29.	Шат тавцан буюу өндөр дээр ажиллах үеийн ААЗ №	29	7	2021.08.16
30.	Паяльникаар ажиллах үеийн ААЗ № 30	30	3	2021.08.16
31.	Маркшейдерийн туслах ажилтны хэмжилт хийх үед	31	5	2021.08.16
32.	Ахлах тогооч, тогооч, бэлтгэгч нарын мөрдөх ААЗ №	32	8	2021.08.16
33.	Үйлчлэгч, угаагч нарын мөрдөх ААЗ № 33	33	5	2021.08.16
34.	Насосны машинчийн мөрдөх ААЗ № 34	34	7	2021.08.16
35.	Үйлдвэрлэл, уурхайд зочдын мөрдөх дүрэм № 35	35	3	2021.08.16
36.	Сэрээт ачигчийн операторын мөрдөх ААЗ №36	36	6	2021.08.16
37.	Өөрөө буулгагч 3 дугуйтын жолоочийн мөрдөх ААЗ	37	5	2023.03.25
38.	Тэсэлгээний цооног өрөмдөх өрөмдлөгийн машины	38	10	2023.02.19
39.	Белаз автосамосвалын операторын мөрдөх ААЗ №38	39	10	2023.02.19
40.	Автогрейдерийн операторын мөрдөх ААЗ №39	40	8	2023.02.19
41.	Шууд утгуурт гидро экскаваторын операторын	41	6	2023.02.19
42.	Дугуйт бульдозерын операторын мөрдөх ААЗ №41	42	7	2023.02.19
43.	Гинжит бульдозерын операторын мөрдөх ААЗ №42	43	7	2023.02.19
44.	XDF-10 хуурай баяжуулах үйлдвэрийн ААЗ №43	44	5	2023.05.09
45.	Шатхуун түгээх станцад орлого хүлээж авах үеийн	45	3	2023.05.30

7.2.3 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх


Үйлдвэрлэл уурхайн нийт ажилтнуудад MNS4969:2000 стандартын дагуу нийт давхардсан тоогоор 802 ажилтанд **411 хүн/цагийн** сургалт, зааварчилгааг зохион байгуулсан.



Зураг 62 Сургалтын явц

7.2.4 Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэрэгслээр хангах

ХАБЭА-н тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан ЗГ-ыг тогтоол, тушаал, дүрэм, журам, стандартын дагуу ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, хор саармагжуулах бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй олгон ажиллаж байна.



#	Хүсн...	Тайлбар...	Баян	Эдийн д...	Анхила	Урс...	Зарилга	Ахлах...	ХА аж...	Ний...	Заснал...	ХА а...	Сал...	Сект...	Хэмжиг...	Тайла...	Тоо хил...	Төлөөл...	PO үүс...	Харцу...
*	ХТКМ/2023/10-1273 (1)																24.00		0.00	
*	ХТКМ/2023/10-1272 (1)																1.00		0.00	
*	ХТКМ/2023/10-1271 (1)																5.00		0.00	
*	ХТКМ/2023/10-1270 (1)																3.00		0.00	
*	ХТКМ/2023/10-1268 (1)																1.00		0.00	
*	ХТКМ/2023/10-1267 (2)																7.00		0.00	
*	ХТКМ/2023/10-1265 (1)																500.00		0.00	
*	ХТКМ/2023/10-1264 (1)																25.00		0.00	
*	ХТКМ/2023/10-1261 (3)																205.00		0.00	
*	ХТКМ/2023/08-1149 (1)																2.00		0.00	
*	ХТКМ/2023/08-1148 (1)																25.00		0.00	
*	ХТКМ/2023/08-1147 (2)																8.00		0.00	
*	ХТКМ/2023/08-1146 (3)																71.00		0.00	
*	PR2503-18827 (4)																709.00	0.00	0.00	
																	1,586.00		0.00	

Зураг 63 Сар бүрийн захиалга

7.2.5 Ажилд гарахын өмнө эмчийн үзлэгт бүх ажиллагсдыг хамруулах

2025 оны 10 дугаар сарын 26-ны өдөр нийт давтагдсан тоогоор 24,520 ажилтанд эмчийн үзлэг зохион байгуулсан. Үзлэгийн явцад ажилтнуудын амин үзүүлэлтүүдийг дараах байдлаар хэмжсэн.

- Артерийн даралт
- Захын цусны хүчилтөрөгчийн ханалт (SpO₂)
- Зүрхний цохилтын тоо (пульс)
- Биеийн халуун


Мөн ажилтнуудын сайн унтаж амарсан эсэх, ерөнхий зовуурь байгаа эсэхийг асуумжаар тодруулж, ажиллах чадварыг эмчийн дүгнэлтээр баталгаажуулсан. Үзлэгийн дүнгээр ажилтнуудын дийлэнх нь эрүүл, ажиллах чадвартай гэж үнэлэгдсэн бөгөөд илэрсэн бага зэргийн зовуурьтай ажилтнуудад шаардлагатай анхан шатны эмчилгээ, зөвлөгөө өгч ажилласан.



Зураг 64 Анхан шатны үзлэг хийж буй байдал

7.2.6 Гал унтраах багаж хэрэгслээр иж бүрэн хангах, шаардлагатай газарт байрлуулах, зориулалтын дагуу ашиглах, холбогдох хүмүүс тэдгээрийг ашиглах арга ажиллагаанд суралцсан байх

Байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлын талбай, агуулах, техникийн бүсийг гал унтраах анхан шатны багаж, хэрэгслээр иж бүрэн хангаж, шаардлагатай газруудад байршуулсан. Гал унтраах хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах нөхцөлийг бүрдүүлж, холбогдох ажилтнуудад тэдгээрийг зөв ашиглах аргачлал, ажиллагааны талаар сургалт, дадлага зохион байгуулсан.



Зураг 65 Галын хор бэлэн байдал

7.3 Шатах тослох материалын сөрөг нөлөөлөл

7.3.1. Галын багаж, хэрэгсэл авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгаж, сэлбэж байх.

Галын багаж, хэрэгслийг тогтмол шалгаж, шаардлагатай үед сэлбэн шинэчилж байна. Мөн эмнэлгийн анхан шатны тусламжийн тоног төхөөрөмж, хэрэгслийг зориулалтын газарт байнга бэлэн байлгаж, хэрэгцээ гарвал даруй ашиглаж байна.



Зураг 66 Бэлэн байдал

7.3.2 Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах.

Галын болон гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрлэл, уурхайн үйл ажиллагааны онцлогт тохирсон төлөвлөгөө боловсруулан, Гурвантэс сумын ГТУА-67 анги, ӨМА-ийн ОБЕГ, УУАА-р батлуулан ажиллаж байна.



Зураг 67 ГУШТ, АҮХШТ, ГХТөлөвлөгөө

7.3.3 Шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт явуулах

Ажилтнуудад шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээлэлд (MSDS) үндэслэсэн сургалт зохион байгууллаа. Сургалтын явцад материалын аюулгүй хэрэглээ, хадгалалт, ослын үед авах арга хэмжээ, хувийн хамгаалалтын хэрэгсэл хэрэглэх зөвлөмж зэрэг практик мэдээллийг танилцуулж, ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэв.



Зураг 68 Сургалт орж буй байдал

7.3.4. ШТС-ын аюулгүй байдал, бүрэн бүтэн байлгах үүднээс харуул хамгаалалтын ажилтан байнгын байрлах.

ШТС-ын аюулгүй байдал, бүрэн бүтэн байлгах үүднээс "Монголын Алт" (МАК) ХХК-ийн "Харуул хамгаалалт, аюулгүй байдлын газар"-тай гэрээ байгуулан харуул хамгаалалтын ажилтан 24 цагаар байнгын байрлаж хамтран ажиллаж байна.



Зураг 69 ШТС харуулын пост

7.3.5. Шатах тослох материал ачиж буулгах, цэнэглэх хэсгийг хатуу хучилттай болгон, алдагдаж асгарсан тохиолдолд хөрсөнд нэвчүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Шатах тослох материалыг (ШТС) ачих, буулгах болон цэнэглэх үйл ажиллагааг тусгайлан зориулсан хатуу хучилттай талбайд гүйцэтгэж байна. Энэ нь шатахуун, тосолгооны материалын асгаралт, алдагдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, мөн хөрс, усны бохирдол үүсгэх эрсдэлийг бууруулах зорилготой. Аливаа асгаралт, алдагдал гарсан тохиолдолд тухайн хэсэгт элс, шингээгч материал ашиглан яаралтай цэвэрлэж, бохирдсон хольцыг тусгай зориулалтын саванд цуглуулж, бохирдсон хөрсийг түр хадгалах талбайд буулган саармагжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.



Зураг 70 Хатуу хучилттай талбай

8.ХОГ, ХАЯДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлын нөлөөллийг бууруулах арга зам

Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашиглах боломжтой хаягдлыг боловсруулах, дахин ашиглах боломжгүй үлдсэн хог хаягдлыг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу устгах ажлыг хэрэгжүүлж байна. Ажилчдыг холбогдох сургалтад тогтмол давтамжтайгаар бүрэн хамруулдаг. Ахуйн бохир усыг Бохир ус цэвэршүүлэх байгууламжид цэвэрлэдэг. Хог хаягдлыг зохих журмын дагуу хадгалах, устгах, булшлах үйл ажиллагаа явуулж буй “Шугшаа уул” ОНӨААТҮГ-д гэрээний дагуу сар бүр 20м³ хог хаягдлыг нийлүүлдэг.

Хог хаягдал

Төслөөс гарах хатуу хог хаягдлын хувьд ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай хаягдал гарах бөгөөд 270 орчим ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог, цаас гэх зэрэг хуурай хаягдлууд хамаарна. Үйлдвэрийн гаралтай хатуу хог хаягдлын хувьд гадаад дотоод овоолгод байршуулагдах хөрсний чулуулаг, хөрс хуулалтын ажлын явцад хуулагдах балансын нөөцийн зарим хэсэг, ус цэвэрлэх цөөрөм, байгууламжийн тундас зэргээс мөн хаягдал шуудай, машин техник, тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн хаягдал болон төмөр утас зэрэг хаягдлууд хамаарна. Үүнээс мятал болон бусад дахин ашиглах боломжтой хог хаягдлыг тусгай талбайд хурааж, тээвэрлэн борлуулах арга хэмжээ авах нь зүйтэй. Уурхайн хатуу хог хаягдлаас төмөр, хөнгөн цагаан, хүхэр, натри, магни, кали, кальци, цахиур, титан болон бичил элементүүд орчныг бохирдуулж болзошгүй. Гиймээс уурхайн олборлолтын явцад уурхайн үйл ажиллагаа болон ажилчдын ахуйн хэрэглээний хатуу хог хаягдлыг дахин боловсруулж болох, эс болох төрлөөр нь ангилан дахин боловсруулж болох хаягдлыг түүхий эд авах цэгт тушааж, дахин боловсруулахгүй хогийг сумын нэгдсэн хогийн цэгт нутгийн захиргаатай гэрээ байгуулан хаях шаардлагатай. Мөн хатуу хог хаягдал түр хаях цэгийн талбайн бохирдлыг хөрсөнд нэвчихгүй байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал.

Шингэн хаягдал

Уурхайн шингэн хаягдалд уурхайн хаягдал ус болон уурхайн ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах шингэн хаягдал зэрэг багтах бөгөөд эдгээрээс тунадас бодис, нефтийн бүтээгдэхүүнүүд, фенол, сульфат, хлорид, карбонат, гидрокарбонат, азотын нэгдлүүд, хүнд болон хөнгөн металлуудын ионууд, бактери зэрэг бохирдуулагч элементүүд үүснэ.

Хийн хаягдал

Машин механизмын хөдөлгүүрээс утаа, угаар, хөө, тортог, хорт бодис ихээр агаарт хаягддаг. Энэ нь агаар орчныг бохирдуулах, ажиллагсдын эрүүл мэнд болон ойр орчмын хөрс, ургамлын бүрхэвчид муугаар нөлөөлж болзошгүй байна. Хийн хаягдлуудаас шалтгаалан тоос, тортог, азот, нүүрстөрөгчийн ислүүд, хүхрийн давхар исэл, хүхэрлэг устөрөгч, аммиак, формальдегид, фосфорын ангидрид, хлор, бензапирен болон бусад бичил элементүүд ялгаран агаар орчинг бохирдуулж болзошгүй.

Уурхайн үйл ажиллагааны улмаас үүссэн ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг анхан шатанд нь ангилан ялгалт хийж хог хаягдлын хэмжээг багасгах, дахин ашиглагдах хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай хадгалах, ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд уурхайн хэмжээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

- Төв оффис, Уурхайн орчны цэвэрлэгээ
- Хатуу хог хаягдлын хадгалалт, хяналт
- Ахуйн хог хаягдлын ангилан ялгалт
- Хатуу хучилтын 5бкм авто замын хажууг цэвэрлэх
- ШТС-ын ойр орчим

Уурхайн болон ахуйн хэрэглээнээс үүсэж бий болсон хогыг ангилан ялгаж хогийн түр цэгт хадгалдаг. Мөн орчны цэвэрлэгээг тогтмол хийдэг бөгөөд уурхайн тосгон, ажилчдын тосгон, уурхай хүртэлх замын дагуух хог зэргийг цэвэрлэдэг.

Химийн бодисын эрсдэлийн менежмент

Аюултай химийн бодис уурхайд ашигладаггүй “Бласт” ХХК-иар тэсэлгээний ажлыг гэрээгээр хийлгэх бөгөөд үүссэн хог бохирдлыг бүрэн хариуцан технологийн дагуу өрөмдлөг тэсэлгээний ажлыг хийдэг. Уурхайн ашиглалтын явцад уурхайн хүнд машин механизмын эд анги, ашиглагдсан тос, тослох

материал, аккумулятор, дугуй гэх мэт сэлбэг хэрэгсэл, дахин ашиглагдах хоёрдогч түүхий эдийг тодорхой цэгт төвлөрүүлэн хуримтлуулан хадгалж байгаад хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлдэг.

Шатахуун түгээх станцын химийн бодисын эрсдэлийн менежмент

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгж өртөг сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт
1	ШТС-ын орчимд нефть бүтээгдэхүүн алдагдах	Энэ тохиолдолд ШТС-ын үйл ажиллагааг бүрэн хааж, объектийг тойруулан харуул тавьж, асгарсан нефть бүтээгдэхүүнийг арилгах цэвэрлэх, хуримталсан уурыг тараан сарниулах нөхцөлийг даруй бүрдүүлэх	Үйл ажиллагааны хүрээнд	ҮЗ	Осол аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бэлэн байх	ХАБЭА-н тухай хууль ШТС-ын техникийн ерөнхий шаардлага
2	Автоцистернээс нефть бүтээгдэхүүн буулгах үед хараа хяналтгүй орхиж явснаас амьсгалах клапан бөглөрч нефтийн уур агаарт алдагдах	Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын хугацаанд байнга хяналт тавьж ажиллах	ШТС-д ашиглагддаг тоног төхөөрөмжүүд	ҮЗ	Жил бүр	Даралтат савыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм
3	Шатахуун хадгалах нөөцлүүр савны эвдрэл, гэмтэл, цоорох	ШТС-д эко бие засах газартай байх	Үйл ажиллагааны хүрээнд	ҮЗ	Жил бүр	
4	Ахуйн ариун цэвэр хангаагүй зориулалтын бус жорлонгоос халдварт өвчин үүсэх	ШТС-ын эсэргүүцэл, цахилгаан утас, тоног төхөөрөмжийн цахилгааны асуудлыг цахилгааны инженерээр байнга шалгуулж байх.	Үйл ажиллагааны хүрээнд	ҮЗ	Жил бүр	220 кв түүнээс бага хүчдэлийн цахилгаан тоног төхөөрөмж тэдгээрийн барилга байгууламжийг аянгаас хамгаалах дүрэм ба бүдүүвч

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая/төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая/төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	1.Хог хаягдлыг цуглуулахад стандартын шаардлага хангасан савыг сонгох, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газруудад байрлуулах, засварлаж байх	Төслийн хүрээнд	ширхэг	0.2	6	1.2	Жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
		2.Хог хаягдлын ангилан ялгалт тухай бүр хийнэ.	Төслөөс гарах хог хаягдал	-	-	-	-	Жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
		3.Хог хаягдлыг түр хадгалах цэгүүдийн зэрэглэлээс хамааран хашлага хийх бүрэн бүтэн байдалд хяналт тавих.	Хог хаягдал түр хадгалах цэг	ширхэг	-	-	-	жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
		4.Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших.	Төслийн хүрээнд	удаа	-	12	-	жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
		5.Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах ажилд бусад уурхайнуудтай хамтран ажиллах.	Хог хаягдал түр хадгалах цэг	-	5	1	2	Жилийн турш	
2	Үйлдвэрийн	1.Хог хаягдлын хадгалалт, хяналт. Машин механизмаас эд анги, ашиглагдсан тос, тослох материал, шатахуун, аккумулятор, дугуй гэх мэт сэлбэг хэрэгсэл, дахин ашиглагдах хоёрдогч түүхий эдийг тодорхой түр цэгт төвлөрүүлэн хуримтлуулан хадгалж байгаад	Төслийн хүрээнд	удаа	-	2	-	жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь

		хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлнэ.							
3	Аюултай	1.Аюултай хог хаягдлыг зориулалтын саванд түр хадгалах /шатах тослох материал/	Төслийн хүрээнд	тонн	-	2	-	жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
		2.Аюултай хог хаягдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагуудтай гэрээлэн нийлүүлэх замаар эх үүсвэр дээрээс зайлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	удаа	-	-	-	жилийн турш	Хог хаягдлын тухай хуудь
	Нийт						6.2		

8.1 Ахуйн хог хаягдал

8.1.1 Хог хаягдлыг цуглуулахад стандартын шаардлага хангасан савыг сонгох, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газруудад байрлуулах, засварлаж байх

Хог хаягдлыг цуглуулахад стандартын шаардлага хангасан савыг сонгох, ажилчдын байр, оффис, агуулах зэрэг газруудад байрлуулж байна.



Зураг 71 Хогийн сав байрлуулалт

8.1.2 Хог хаягдлын ангилан ялгалт тухай бүр хийнэ.

Ажиллагсад хог хаягдлыг ангилан ялгах, ангиллын дагуу хадгалах арга болон ямар хог хаягдлыг ямар саванд хийх, дахин боловсруулах талаар сургалт, зааварчилгаа тогтмол өгч байна.



Зураг 72 Хог хаягдлын сургалт орж буй байдал



Зураг 73 Ахуйн хог хаягдал ангилан ялгалт

8.1.3 Хог хаягдлыг түр хадгалах цэгүүдийн зэрэглээс хамааран хашлага хийх бүрэн бүтэн байдалд хяналт тавих


Хог хаягдлыг түр хадгалах цэгүүдийг тусгай зэрэглэл, ангилалд тохируулан хашлагаар хамгаалж, бүрэн бүтэн байдалд хяналт тавьж байна.



Зураг 74 Хог хаягдлын цэг

8.1.4 Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших

Уурхайн болон ахуйн хэрэглээнээс үүсэж бий болсон хогыг ангилан ялгаж хогийн түр цэгт хадгалдаг. Мөн орчны цэвэрлэгээг 7 хоног бүр тогтмол хийдэг бөгөөд уурхайн тосгон, ажилчдын тосгон, уурхай хүртэлх замын дагуух хог зэргийг цэвэрлэдэг.



Зураг 75 Их цэвэрлэгээ хийж буй байдал

8.1.5 Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах ажилд бусад уурхайнуудтай хамтран ажиллах

Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах ажилд бусад уурхайнуудтай хамтарсан уулзалт зохион байгуулж. Уг ажлыг судалгаа шинжилгээний үндсэн дээр хийж хэрэгжүүлэхээр санал нэгдэж Өмнөговь аймгийн байгаль орчны газарт хүсэлт гаргаж Гурвантэс сумаас газрын асуудал шийдвэрлүүлэх түүний дараа ТЭЗҮ хийлгэхээр ажиллаж байна.

8.2 Үйлдвэрийн хог хаягдал

8.2.1 Машин механизмаас эд анги, ашиглагдсан тос, тослох материал, шатахуун, аккумулятор, дугуй гэх мэт сэлбэг хэрэгсэл, дахин ашиглагдах хоёрдогч түүхий эдийг тодорхой түр цэгт төвлөрүүлэн хуримтлуулан хадгалж байгаад хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлнэ.

Ашигласан машин механизмын эд анги, тос, тослох материал, шатахуун, аккумулятор, дугуй болон бусад сэлбэг хэрэгсэл, дахин ашиглагдах хоёрдогч түүхий эдийг тодорхой түр хадгалах цэгт төвлөрүүлэн хуримтлуулан зохих журмын дагуу хадгалж байна. Хяналтын үр дүнд “Эко окто хүрд” ХХК-д 184 ширхэг хаягдал дугуй хүлээлгэн өгсөн.



Зураг 76 Хог хаягдал тэвэрлэж буй байдал

8.3 Аюултай хог хаягдал

8.3.1 Аюултай хог хаягдлыг зориулалтын саванд түр хадгалах /шатах тослох материал/

Бохирдсон тос, тослох материалыг уурхайн тосгоны зүүн урд байрлах тос солих цэгт бэлтгэсэн 30 тонн багтаамжтай ёмкост хадгалж байна.

8.3.2 Аюултай хог хаягдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагуудтай гэрээлэн нийлүүлэх замаар эх үүсвэр дээрээс зайлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх

Уурхайд аюултай химийн бодис ашигладаггүй бөгөөд тэсэлгээний ажлыг “Бласт” ХХК-тай гэрээний дагуу гүйцэтгүүлж байна. Тус компани тэсэлгээний явцад үүссэн хог, бохирдлыг бүрэн хариуцах бөгөөд технологийн дагуу өрөмдлөг, тэсэлгээний ажлыг чанартай гүйцэтгэдэг. Мөн уурхайн ашиглалтын явцад уурхайн хүнд машин механизмын тос, тослох материал зэрэг түүхий эдийг тодорхой цэгт төвлөрүүлэн хуримтлуулж хадгалж, шаардлагатай үед хувь хүн болон аж ахуйн нэгжүүдэд нийлүүлж байна.

2025 онд “Об ойл Индустриал” ХХК болон “Түмэн Эгшиг” ХХК-тай хамтран ажиллаж гэрээний дагуу акт үйлдэн 60 тонн хаягдал тосоо хүлээлгэн өгсөн байна. Мөн 384 ширхэг хаягдал поошиг тээвэрлүүлсэн. Аюултай хог хаягдлыг тусгай цэгт байршуулаад байна.



Зураг 77 Хаягдал тос ачуулж буй байдал

9.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго зорилтууд

“Хүрэн толгой” нүүрсний уурхайг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүнийг тодорхойлох арга, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, холбогдон гарах зарим зардлуудын хамт тодорхойлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулсан болно.

Орчны хяналт шинжилгээний нэгдсэн хөтөлбөр нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэг чухал хэсэг байдаг бөгөөд төслийн үйл ажиллагаа байгаль орчин, нутгийн иргэд, ажиллагсдын амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг хянах орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх удирдамж болдог.

Тус төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, төслийн сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөх зорилготой. Өөрийн хяналт, шинжилгээний багажаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл зэрэгт байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Байгаль орчны 7 бүрэлдэхүүн хэсэгт хийгдэх нийт 9 төрлийн хяналт шинжилгээ явуулах хэлбэрийг боловсруулан оруулав. Зардлын тооцоонд зөвхөн дээж сорьцыг авах болон түүнийг шинжлүүлэх лабораторийн шинжилгээний зардлыг тооцсон.

Орчны хяналт шинжилгээний ажлыг жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн тайланд оруулж байгаль орчны асуудал эрхэлсэн орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана. Мөн байгууллагын дотоодын хяналтыг хэрэгжүүлэх, төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг тухай бүр хянах, цаг алдалгүй хариу арга хэмжээ авах зорилгоор байгаль орчны асуудал хариуцсан ажилтан сар болон улирал тутам хяналт шинжилгээний дүн мэдээгээр тайлан бэлтгэж, зохих удирдлагадаа тайлагнаж байна.

Хүрэн толгойн уурхайн онцлог нь энэ бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад уурхайн үйл ажиллагаанаас үзүүлж буй сөрөг нөлөөлөл хуримтлагдах, хамсах нөхцөлтэй бөгөөд ялангуяа энэ нь агаар орчинд үзүүлж буй нөлөөлөл дээр тод илэрнэ. Иймээс уг бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй төсөл хэрэгжүүлэгчид байгаль хамгаалах үйл ажиллагаагаа хамтран зохион байгуулах нь илүү үр дүнтэй байх болно.


Орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэхдээ төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтан хээрийн хэмжилт дээжлэлтийг хийх ба үр дүнг тайлагнахдаа Монгол улсын холбогдох стандартад харьцуулан үзэх, мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтран ажиллаж зөвлөгөө авах, итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажиллах, эрх бүхий субьектээр дүгнэлт гаргуулах хэлбэрээр ажилласан.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
АГААРЫН ЧАНАР								
1.	Агаар дахь тоосжилтын хяналт	- Карьерын орчимд, - Овоолгын орчимд - Уурхайн тосгон - ШТС	Сар бүр	12	-	-	Өөрийн тоос хэмжигч багаж	MNS 4585:2007 MNS:3384:1982 MNS:4048:1988
ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УС								
1.	Гадаргын болон газрын доорх усны чанар: Гол ионы найрлага: анион, катион, микро элементийн агууламж, Ундны усны микробиологийн хяналт шинжилгээ	- Уурхайн худаг бүрээс /нийт-3 худаг/ - Уурхайн шүүрлийн уснаас /1 цэгээс /	Улирал тутам	4	0.625	2.5	Хэмжилзүйн лабораторитай хамтран ажиллана.	MNS 900:2005
2.	Ахуйн хаягдал усны хяналт шинжилгээ	Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламж	Жилд 1 удаа	1	0.1	0.1		-
ХӨРСӨН БҮРХЭВЧ								

1.	Ялзмагийн агууламж, рН, давсжилт, чийгшил, NO ₃ -N, P ₂ O ₅ , K ₂ O, рН, нийт азот, нийт фосфор,	- Нөлөөлөлд өртөөгүй талбай - Шимт хөрсний овоолго	Жилд 2 удаа	2	0.2	0.4	Хэмжилзүйн лабораторитай хамтран ажилла	MNS5850:2008
2.	Нефть, нефтийн бүтээгдэхүүн, нүүрс устөрөгчид, хүнд металлын агууламж микробиологийн үзүүлэлт	- Хогийн цэг - Цэвэрлэх байгууламжийн дэргэд - Засвар үйлчилгээний төвийн дэргэд - Шимт хөрсний овоолгоос - ШТС	Жилд 2 удаа	2	0.2	0.4	Хэмжилзүйн лабораторитай хамтран ажилла	MNS 5850:2008
АМЬТНЫ АЙМАГ								
1.	Амьтны төрөл зүйл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн	Нийт тусгай зөвшөөрлийн талбайд	Жилд 1 удаа	1	8.5	8.5	Мэргэжлийн байгууллага МАК-Нарийн сухайтын уурхайтай хамтран хэрэгжүүлэх	Батлагдсан арга зүйн дагуу
	Нийт					11.9		

9.1 Агаарын чанар

2025 онд уурхайн бүсэд агаарын чанарын хяналт, шинжилгээг (Агаарын тоос хэмжигч /CASELLA-cel2712) багажаар сар бүр тогтмол хийж гүйцэтгэсэн. Үүнд агаарын тоос хэмжигч болон халаасны анемометр зэрэг багажаар хэмжилт хийсэн бөгөөд тоосжилтын түвшин нэмэгдэх үед зам, талбайн усалгааг ойртуулж, тоосжилтыг бууруулах арга хэмжээг уурхайн үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлсэн.



Зураг 78 Хэмжилт хийж буй байдал

9.2 Гадаргын болон газрын доорх ус

Уурхай орчмын газрын доорх усны хяналт, шинжилгээний ажлыг улирал бүр тогтмол хийж, усны лабораторитой хамтран дээж авч “Трү Ти Ар Си”ХХК-д шинжилгээнд хамруулсан. Хяналт-шинжилгээний ажлын үр дүнгээс дараах дүгнэлтүүд гарсан байна:

1. **Газрын доорх усны түвшин:**
 - Уурхайн ахилтад өртсөн бүсэд газрын доорх усны түвшин хэвийн байна.
 - Харин нөлөөллийн бүсэд усны түвшний мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдаагүй.
2. **Усны химийн найрлага ба төрөл:**
 - Кемпийн зоогийн газрын унд ахуйд ашиглаж буй усны эрдэсжилт бага, усны төрөл **натри-гидрокарбонат (Na–HCO₃)** байна.
 - Нөлөөллийн болон уурхайн бүсийн усны найрлага ижил төрөлтэй, буюу натри-сульфат (Na–SO₄) төрөлд хамаарна.
3. **Ундны усны чанарын үнэлгээ:**
 - Ашиглалтын худгийн ус Монгол Улсын MNS 0900:2018 “Ундны ус” стандартад нийцэж байна.
 - Шүүлтүүрээс гарсан усанд гидрокарбонатын агууламж болон нийт эрдэсжилт эрс буурч байгаа нь ус цэвэршүүлэх систем хэвийн ажиллаж байгааг харуулж байна.
 - Унд ахуйд хэрэглэж буй усанд гидрокарбонатын ионы эзлэх хувь бага байна.



Зураг 79 Усны түвшин хэмжилт



Зураг 80 Усны дээж авалт

9.3 Хөрсөн бүрхэвч

2025 онд уурхайн 7 байршлаас хөрсний дээж авч, “Тру Ти Ар Си” ХХК нь хэмжил зүйн лабораторид шинжилгээнд хамруулсан.



Зураг 81 Хөрсний дээж авалт

9.4 Амьтны аймаг

Орчны хяналт-шинжилгээний ажлыг “Монголын Алт” (МАК) ХХК-ийн Нарийн сухайтын уурхайтай хамтран, “Эко Ногоон Баялаг” ХХК-тай гэрээ байгуулсан. Гэрээний хүрээнд уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, хяналт-шинжилгээ хийх зорилгоор ус, хөрс, агаар, амьтан, ургамлын чанар, төлөв байдлыг тодорхойлох судалгааг мэргэжлийн судлаачдаар хийлгэж, хяналт-шинжилгээний ажлын хүрээнд тодорхойлогдсон хяналтын цэгүүдээс ус, хөрс, агаар, биологийн төрөл зүйл (амьтан, ургамал)-ын

дээжийг авч, лабораторийн болон талбайн судалгааг хийж гүйцэтгэнэ. Судалгааны үр дүн, шинжилгээний дүгнэлтийн үндсэн дээр уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил хийж хэрэгжүүлнэ.

10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

1. Өмнөговь аймгийн засаг даргын дугаар 01/1062, Гурвантэс сумын засаг даргын дугаар 01/249 албан тоотуудын дагуу тус суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд, орон нутгийн зорчигч, ачаа тээврийн хөдөлгөөний улмаас гарч байгаа олон салаа шороон зам гаргаж байгаа үйл явцыг зогсоон хөрсний эвдрэл, тоосжилт, малчдын бэлчээр, байгаль орчны доройтол, заган ойн нөөц хамгаалах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор Даланзадгад-Гурвантэс сум чиглэлийн хатуу хучилттай авто замын 222 дахь километрээс сумын төв хүртэлх 74 км шороон замын хэсгээс Хүрэн толгой уурхайн 15км технологийн шороон зам байгуулсан.

2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилт, газрын доройтол, шороон шуурганы эх үүсвэрийг бууруулах, говийн бүс нутгуудад заган ойг нөхөн сэргээж элсний нүүдлийг тогтоон барих, говийн биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар өгсөн чиглэлийн дагуу 10 га газарт заган ой үүсгэсэн.

3. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын засаг даргын 2025 оны 02-р сарын 14-ний өдөр дугаар 1/125 албан тоотыг үндэслэн, “Хүрэн толгой коал майнинг”ХХК-ийн уурхайн хотхоны засмал замаас Гурвантэс сум чиглэлийн сайжруулсан шороон замын трассын дагуу тус компанид хуваарилагдсан 4.1 км хэсгийн засаж сайжруулах ажил хийж гүйцэтгэсэн.

4. МАК Нарийн сухайтын уурхай, АӨГСГЗ-тай хамтран Өмнөговь аймгийн хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, албан байгууллагуудын дунд “Усыг хайрлан хамгаалах талаар хэн сайн суртачлах вэ?” тэмцээнүүдийг тус тус зохион байгуулсан.

11.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу уурхайн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, түүний биелэлтэнд хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг мэргэжлийн ажилтан, багт хариуцуулах
- Байгаль орчныг хамгаалах болон хөдөлмөр хамгаалах, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтан нь уурхайн дээд шатны удирдлагад шууд харьяалагдаж ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг төлөвлөж ажиллах
- Олборлолт явуулсан талбайн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай зэрэгцүүлэн хийх
- Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэж өгөх
- Уурхайн бүх ажлыг ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу явуулах, технологийн процессыг паспортжуулах
- Олборлолтын явцад археологи , палентлоги, түүх, соёлын дурсгалт зүйлс илэрвэл сумын ЗДТГ, мэргэжлийн зохих байгууллагад яаралтай мэдэгдэж хамгаалах арга хэмжээ авах
- Орон нутгийн засаг захиргаа олон нийтийн байгууллага иргэдийн санал бодлыг сонсож зохих арга хэмжээ авах харилцан мэдээлэл солилцож байхаас гадна ажилчдын эрүүл мэнд байгаль орчныг хамгаалах, гэнэтийн болзошгүй осол аюулыг арилгах чиглэлээр аймгийн мэргэжлийн хяналтын газар болон сумын ЗДТГазартай нягт хамтарч ажиллах
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл газар хөдлөлт үер салхи шуурга болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг нэгээс хоёр удаа сургаж дадлагажуулах энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллах
- Уурхайн ажиллагсдын дунд байгаль хамгаалах талаар ухуулга яриа сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- Хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж байнга бэлэн байлгах
- Уурхайн ухаш усан сан болон суваг шуудуу нь хүн мал амьтан унах живж осолдохоос сэргийлсэн хаалт хашлагатай байх бөгөөд эргэн тойронд нь анхааруулах хориглох санамж тавьж ослоос сэргийлэх арга хэмжээ авах
- Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч ус хөрс агаарын бохирдол хөрсний эвдрэл элэгдэл усны нөөцийн байдалд хяналт тавьж ажиллах

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв сая.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Хэрэгжилт
			2025 он				
			Сар	Сар	Сар		
1.	Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах;	Цалингийн сангаас	Үйл ажиллагааны турш			Уурхайн удирдлага	БОТХХэсэг нь нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
2.	Байгаль орчны ажилчдыг мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт хамруулж байх	1.2	2	3	9	Уурхайн удирдлага	Байгаль орчин нийгэм засаглал стандартын хүрээнд холбогдох хүлэмжийн хийн сургалт болон ногоон барилга байгууламжийн сургалтанд хамрагдсан.
3.	Уулын ажлын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар тодорхой ажлуудыг тусган түүнийг мөрдөн ажиллах	ҮЗ	Үйл ажиллагааны турш			Байгаль орчны инженер	Байгаль орчныг хамгаалах талаар шимт хөрсний овоолго, нөхөн сэргээлт, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тусган ажиллаж байна.
4.	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах, зохих төрийн захиргааны төв байгууллагуудад хянуулан батлуулж ажиллах	ҮЗ	10	12	1	Байгаль орчны инженер	2025 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан хийгдсэн. Зохих төрийн захиргааны байгууллагуудад хянуулан батлуулж байна.
Нийт		1.2					

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, Сая.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Гурвантэс сумын ЗДТГ, нутгийн иргэдэд	Уулзалт, хурал, цуглаан	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	Тухай бүрт	1.0	БОИ	Бага овоо багийн төвд
2.	Өмнөговь аймаг Байгаль орчны газар	БОМТБТайлан хүргүүлсэн		11-р сарын 01-ний дотор	-	БОИ	Төслийн талбай, уурхай
3.	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т албан бичиг	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр болон Файл хэлбэрээр		2026 оны 1-р улиралд	-	БОИ	Улаанбаатар хот
	Нийт				1.0		

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
биелэлтийн нийт зардал**

№	Төлөвлөгөөт ажлын бүрэлдэхүүн	Төлөвлөгөө /сая.төг/	Тайлан /сая.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10.6	65.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	43.6	274.6
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	30.0	25.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5.5	19.9
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ҮЗ	ҮЗ
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	6.2	35.2
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	11.9	13.0
9	Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	-	1.163.3
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	1.2	-
11	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	1.0	-
	Дүн	110	1.552.9
Үйлдвэрлэлийн зардлаас			
1	Хог хаягдал төлбөр		4.4
2	Ус ашигласны төлбөр		1.7
3	Газар ашигласны төлбөр		90.3
4	БОННУ		23.1
5	Археологи, Палетологи, Угсаатан зүйн судалгаа		31.7
			151.2